



Mongol Bank



МОНГОЛБАНК

ИНФЛЯЦЫН ТАЙЛАН

2022

9-Р САР

АГУУЛГА

<i>МӨНГӨНИЙ БОДЛОГЫН СТРАТЕГИ</i>	3
<i>МӨНГӨНИЙ БОДЛОГЫН ШИЙДВЭР</i>	4
<i>ТОЙМ</i>	5
<i>I. ИНФЛЯЦ</i>	7
Инфляцын цаашдын төлөв.....	8
<i>II. ЭДИЙН ЗАСГИЙН ӨСӨЛТ</i>	14
Нийт эрэлт.....	14
Нийт нийлүүлэлт.....	15
Потенциал үйлдвэрлэл.....	17
Үйлдвэрлэлийн зөрүү.....	17
Эдийн засгийн өсөлтийн цаашдын төлөв.....	18
<i>III. ДОТООД ЭДИЙН ЗАСГИЙН ОРЧИН</i>	20
III.1. Хөдөлмөрийн зах зээл.....	20
III.2 Мөнгө, санхүүгийн зах зээл.....	22
III.2.1 Мөнгө, зээлийн үзүүлэлтүүд.....	22
III.2.2 Хүү.....	25
III.2.3 Валютын ханш.....	26
III.2.4 Хөрөнгийн зах зээл.....	27
III.3 Нэгдсэн төсөв болон Засгийн газрын өр.....	30
<i>IV. ЭДИЙН ЗАСГИЙН ГАДААД ОРЧИН</i>	32
IV.1 Эдийн засгийн гадаад орчны төсөөлөл.....	32
IV.2 Түүхий эдийн үнэ.....	33
IV.3 Төлбөрийн тэнцэл.....	34

МӨНГӨНИЙ БОДЛОГЫН СТРАТЕГИ, АРГА ХЭРЭГСЭЛ

Төв банкны тухай хуульд **Монголбанкны үндсэн зорилт нь үндэсний мөнгөн тэмдэгт төгрөгийн тогтвортой байдлыг хангах** гэж тодорхойлсон байдаг. Энэ зорилтын хүрээнд Монголбанк хэрэглээний үнийн индексээр хэмжигдэх инфляцыг дунд хугацаанд зорилтот түвшний орчимд тогтворжуулах бодлогыг “Төрөөс мөнгөний бодлогын талаар баримтлах үндсэн чиглэл”-д тусган хэрэгжүүлж байна. Инфляцыг нам түвшинд тогтворжуулснаар иргэдийн бодит орлого, хөрөнгийг үнэгүйдлээс хамгаалж, банк санхүүгийн тогтолцооны тогтвортой байдал хангагдах нөхцөлийг бүрдүүлэх төдийгүй хөрөнгө оруулалт, эдийн засгийн өсөлтийн тогтвортой байдлыг дэмжинэ. Монголбанк **инфляцыг 2022-2024 онд жилийн 6 хувь орчимд, +/-2 нэгж хувийн интервалд тогтворжуулахыг** зорьж байна.

Монголбанкнаас мөнгөний бодлогын хүрээнд бодлогын хүүг өөрчилснөөр санхүүгийн зах зээлийн хүү, мөнгө, зээлийн эрэлт, нийлүүлэлтэд, улмаар үйлдвэрлэлийн хэмжээ, хөрөнгийн үнэ, хүлээлт, валютын ханш, дотоод эрэлтэд нөлөөлөх замаар инфляцын түвшин, түүний хүлээлтийг тогтворжуулахыг зорьдог. Түүнчлэн, 2018 оноос эхлэн макро зохистой бодлогын хүрээнд системийн хэмжээнд мөрдүүлэхүйц банкны зохистой харьцааны хэрэгслүүдээр дамжуулан банкны зээлийн хэт өсөлт, үүний аль нэг салбар, бүтээгдэхүүн эсвэл гадаад валютад хэт төвлөрсөн байдлыг оновчтой удирдах зэрэгт чиглэсэн арга хэмжээг мөнгөний бодлогын арга хэрэгслүүдтэй хослуулан хэрэглэх стратегийг баримталж байна.

Монголбанк мөнгөний бодлогын үр нөлөөг сайжруулахын тулд олон нийттэй харилцах харилцааны нээлттэй байдалд ач холбогдол өгч байна. Иймд Монголбанк макро үзүүлэлтүүдийн гүйцэтгэл, инфляц, эдийн засгийн ойрын төлөв байдал, түүнд нөлөөлж буй гадаад эдийн засаг, санхүүгийн салбар, нийт эрэлт, нийлүүлэлт, ажил эрхлэлт, үнэ, өртгийн хүчин зүйлс зэргийг Инфляцын тайланд танилцуулж, улирал тутам олон нийтэд мэдээлж байна. Төв банкны зорилтод нийцтэй, инфляцын төсөөлөлд үндэслэн авч хэрэгжүүлсэн мөнгөний бодлогын арга хэмжээ, үр дүнг олон нийтэд нээлттэй танилцуулснаар бодлогын ил тод байдлыг хангах, Монголбанканд итгэх итгэлийг дээшлүүлэх замаар зах зээлд оролцогчдод ирээдүйн талаар мэдээлэл өгөх, хүлээлтийг удирдах ач холбогдолтой.

Монголбанкны мөнгөний бодлогын үйл ажиллагааны зорилт нь банк хоорондын захын жигнэсэн дундаж хүү байдаг. Энэ зорилтын хүрээнд Монголбанкнаас нээлттэй захын үйл ажиллагаа, хүүгийн нэгдсэн бодлого, репо санхүүжилт болон бусад мөнгөний бодлогын арга хэрэгслүүдийг ашиглаж байна. Мөнгөний бодлогын шилжих механизм ёсоор банк хоорондын захын хүүгийн өөрчлөлт нь хадгаламж, зээлийн хүү болон бусад хөрөнгийн үнэд нөлөөлснөөр инфляц болон тэдгээрийн ирээдүйн төлөвийн талаарх хүлээлтэд нөлөөлдөг. Ингэхдээ бодлогын хэрэгсэл нь эцсийн зорилт болох эдийн засгийн идэвхжил, инфляцад тодорхой хугацааны хоцролттой нөлөөлдөг.

Төв банкны үнэт цаас (ТБҮЦ)-ны арилжаа нь банк хоорондын захын богино хугацаатай хүү, банкуудын эх үүсвэрийн хэлбэлзлийг удирдах замаар мөнгөний бодлогыг хэрэгжүүлэх үндсэн арга хэрэгсэл болж байна. Түүнчлэн бодлогын хүүгийн коридор системтэй уялдуулан мөнгөний бодлогын бусад хэрэгслүүдийн хүү тодорхойлогдож байна.

МӨНГӨНИЙ БОДЛОГЫН ШИЙДВЭР

Монголбанкны Мөнгөний бодлогын хорооны 2022 оны 9-р сарын 16, 20-ны өдрийн ээлжит хурлаар Бодлогын хүүг 2 нэгж хувиар өсгөж 12 хувьд хүргэх шийдвэр гаргалаа. Мөнгөний бодлогын 2022 оны 9-р сарын 20-ны мэдэгдлийн дэлгэрэнгүйг [эндээс](#) уншина уу.

Инфляцын тайланд орсон тоон өгөгдөл, зураг, хүснэгтийг [дараах](#) линкээр татаж авах боломжтой.

© Монголбанк 2022

ТОЙМ

Гадаад эдийн засгийн орчин туйлын тодорхойгүй байна. Олон улсын харилцааны хурцадмал байдал, БНХАУ-ын “Тэг-Ковид” бодлого, үл хөдлөх хөрөнгийн салбарын асуудал, Европын орнуудад үүсээд буй эрчим хүчний хямрал зэрэгтэй холбоотойгоор дэлхий дахинд тодорхой бус байдал нэмэгдэж, дэлхий нийтээр инфляц зорилтот түвшинд тогтворжих хугацаа хойшлох эрсдэл өндөр хэвээр байна. Үүний эсрэг төв банкууд мөнгөний бодлогыг шат дараатай хатууруулж байгаагаас дэлхийн эдийн засаг дунд хугацаанд удаашрах төлөвийг бий болголоо. Манай орны хувьд хилийн хязгаарлалт, бүс нутагт үүссэн геополитикийн хурцадмал байдал эдийн засгийн идэвхжил төсөөллөөс саарах, төлбөрийн тэнцлийн алдагдал хурдтай тэлэх, зардлын болон нийлүүлэлтийн шалтгаантай инфляц нэмэгдэх эрсдэл хэвээр байна.

Инфляцын төсөөлөл энэ онд буурч, ирэх онд бага зэрэг нэмэгдэхээр байна. Инфляц 2022 оны 8 дугаар сард улсын хэмжээнд 14.4 хувь, Улаанбаатар хотод 14.8 хувьтай гарлаа. Инфляцын төсөөлөл энэ онд буурахад шатахууны инфляц өмнөх төсөөллөөс буурсан нь голлон нөлөөлөв. Тодруулбал, ОХУ-аас импортлож буй шатахууны хилийн үнэ буурч, дизель түлшний үнэ энэ оны 8 дугаар сард 300 төгрөгөөр хямдарсан, АИ-92 шатахууныг он дуустал хөнгөлөлттэй үнээр худалдан авахаар болсон нь инфляцын төсөөллийг бууруулж байна. Гэсэн хэдий ч ирэх онд хүнсний үнийн төсөөлөл нэмэгдэх, гадаад үнүүд өсөх, төгрөгийн ханш сулрах, үүнтэй холбоотойгоор импортын бараа, улмаар дотоодын бараа, бүтээгдэхүүний үнэ өсөх нөлөөгөөр инфляцын төсөөлөл дунд хугацаанд бага зэрэг нэмэгдэж, Төв банкны зорилтот интервалд тогтворжих хугацаа хойшлох хандлагатай болов.

Энэ оны эдийн засгийн өсөлтийн төлөвийг сайжрууллаа. Эдийн засгийн өсөлт энэ оны 2 дугаар улиралд төсөөллөөс 3.1 нэгж хувиар өндөр гарлаа. Үүнд нүүрс, зэсийн баяжмалын олборлолт хүлээлтээс бага гарч, уул уурхайн салбарын үйлдвэрлэл төсөөллөөс бага зэрэг муудсан ч эрчим хүчнээс бусад уул уурхайн бус салбаруудын үйлдвэрлэл хүлээлтээс давж, эдийн засгийн өсөлтийг дэмжлээ. Эдийн засгийн өсөлт ийнхүү хүлээлтээс өндөр гарсантай уялдуулан энэ оны өсөлтийн төсөөллийг 3 хувьд хүргэж нэмэгдүүлэв. Уул уурхайн бус салбарт эрчим хүч, боловсруулах, үйлчилгээний салбаруудаас бусад салбаруудын үйлдвэрлэл өмнөх төсөөллөөс нэмэгдэхээр байна. Тодруулбал, цаг агаарын таатай нөхцөл байдал нь хөдөө аж ахуйн салбарыг дэмжих бол хөл хорионы дэглэм суларч, дотоод эрэлт сэргэж байгаатай холбоотойгоор худалдаа, үйлчилгээний зарим салбаруудын идэвхжил үргэлжилж, үүнээс улбаалан татварын орлого бүрдүүлэлт нэмэгдэнэ гэж үзлээ. Хилийн боомтууд дээрх хязгаарлалтууд суларч, экспорт сэргэж байгаатай холбоотойгоор уул уурхайн салбарын өсөлтийг өмнөх төсөөллөөс сайжрууллаа. Харин зээл олголт хумигдсантай холбоотойгоор санхүү, даатгалын үйлчилгээ буурч, үйлчилгээний салбар оны сүүлийн хагаст удаашрахаар байна.

Дунд хугацаанд Оюу толгойн үйлдвэрлэл нэмэгдэх, нүүрсний экспорт хэвийн түвшинд хүрэх, газрын тосны олборлолт сайжрахаар байгаа нь уул уурхайн салбарын өсөлтийг тэтгэх бол гадаад эрэлт саарах, худалдааны нөхцөл муудах, төсвийн төлөв чангарах нь уул уурхайн бус салбарын өсөлтийг сааруулахаар байна.

Нэгдсэн төсвийн 2022 оны 7 дугаар сарын гүйцэтгэлээр тэнцвэржүүлсэн тэнцэл 788 тэрбум төгрөгийн алдагдалтай гарлаа. Төсвийн тэнцвэржүүлсэн орлого 8.7 их наяд төгрөгт хүрч өмнөх оны мөн үеэс 1 их наяд орчим төгрөгөөр буюу 13.7 хувиар нэмэгдсэнээр төсвийн

тэнцвэржүүлсэн орлогын гүйцэтгэл 94.3 хувьд хүрлээ. Харин төсвийн нийт зардал энэ оны 7 дугаар сард өмнөх оны мөн үеэс 1 их наяд төгрөгөөр өсч 9.5 их наяд төгрөгт хүрсэн хэдий ч төсвийн зардал, тэр дундаа төсвийн хөрөнгө оруулалтын зардал дутуу гүйцэтгэлтэй байна.

Мөнгөний нийлүүлэлтийн өсөлт буурах хандлага үргэлжилж, банкуудын зээлийн өсөлт саарч эхэллээ. Өнгөрсөн нэг жил орчмын хугацаанд гадаад валютын цэвэр урсгал сөрөг байгаа нь М2 мөнгөний өсөлт саарахад голлон нөлөөлж байна. Өмнөх оны 1 дүгээр улирлаас хойш тасралтгүй эрчимжиж байсан зээлийн өсөлт энэ оны 4 дүгээр сараас саарч эхэллээ. Банкны системийн зээлийн сарын өсөлт энэ оны 7 дугаар сард -0.6 хувьд хүрч, зээлийн үлдэгдэл өмнөх сараас буурсан дүнтэй байна. “Банкны зээлийн төлөв”-ийн судалгаагаар иргэд болон аж ахуйн нэгжүүдийн зээлийн эрэлт нэмэгдсэн ч эдийн засгийн нөхцөл байдал, эх үүсвэрийн зардал, барьцаа хөрөнгийн эрсдэл зэрэгтэй холбоотойгоор банкууд зээлийн нөхцөл болон шалгуураа бага зэрэг чангаруулсан байна. Банкны системийн эх үүсвэрийн долларжилт сүүлийн саруудад нэмэгдэж, энэ оны 7 дугаар сард 29.3 хувьд хүрсэн нь оны эхнээс 6 нэгж хувиар өссөн үзүүлэлт болов. Харин зээлийн долларжилт буурах хандлага хэвээр байна.

Гадаад эдийн засгийн төлөв муудаж, тодорхой бус байдал нэмэгдэж байна. Энэ нь голчлон 1) ОХУ, Украины мөргөлдөөн, үүнтэй холбоотой хориг арга хэмжээний олон улсын эрчим хүч, хүнсний зах зээлд үзүүлж буй сөрөг үр дагавар, 2) БНХАУ-ын цар тахлын эсрэг хэрэгжүүлж буй “Тэг-Ковид” бодлого, үл хөдлөх хөрөнгийн зах зээлийн хямралтай холбогдож байна. Олон улсын зарим шинжээчдийн үзэж байгаагаар дэлхийн эдийн засгийн төлөвийг сааруулж буй эдгээр нөхцөл байдал ойрын хугацаанд шийдвэрлэгдэхгүй, 2023 онд үргэлжилж болзошгүй байна. Үүнээс гадна, ихэнх төв банкууд инфляцын эсрэг мөнгөний бодлогоо хурдтай чангаруулах болсон нь эдийн засгийн өсөлтийн төлөв сулрах нэг нөхцөл болж байна. Гадаад эдийн засгийн цаашдын төлөв ийнхүү суларч, үүнийг тойрсон тодорхой бус байдал өндөр байгаатай холбогдуулан олон улсын зах зээл дээрх дийлэнх түүхий эдийн үнэ өмнөх төсөөлөлтэй харьцуулахад богино хугацаандаа буурах хандлагатай боллоо.

Төлбөрийн тэнцэл 2022 оны 2 дугаар улиралд 104.4 сая ам.долларын алдагдалтай гарлаа. Үүнд, экспортын орлого өмнөх оны мөн үеэс 400 орчим сая ам.доллаар нэмэгдсэн боловч импортын төлбөр илүү хурдтай өсөж, тээврийн үйлчилгээний зардал тэлсэнээр урсгал тэнцлийн алдагдал өмнөх оны мөн үеэс 115 сая ам.доллаар өссөн нь голлон нөлөөлөв. Санхүүгийн данс ашигтай гарсан хэдий ч урсгал дансны алдагдлыг санхүүжүүлэхэд хангалтгүй байв.

I. ИНФЛЯЦ


Монголбанк хэрэглээний үнийн индексээр илэрхийлсэн инфляцыг 2022-2024 онд жилийн 6 хувийн орчимд, +/-2 нэгж хувийн интервалд тогтворжуулах зорилттой ажиллаж байна.

ХҮИ-ий сагс 5 жил тутам шинэчлэгддэг билээ. 2020 оны сууриар шинэчилсэн сагсыг 410 бараа, үйлчилгээ (Улаанбаатарт 404)-ээр бүрдүүлж, Өрхийн нийгэм, эдийн засгийн судалгааны 2018, 2019, 2020 оны дундаж үр дүнгээр бүлгүүдийн жинг тооцон 2022 оны 8 дугаар сараас мэдээлж эхэллээ.

Энэ оны II улиралд инфляц¹ улсын хэмжээнд 16.3 хувь, Улаанбаатар хотод 16.2 хувь болж өмнөх улирлаас тус бүр 0.9 болон 0.6 нэгж хувиар нэмэгдэв. Инфляц сүүлийн улирлуудад өндөр байгаа нь гадаад орчинд бий болсон өөрчлөлт, түүнтэй холбоотой тээвэр логистикийн хүндрэлээс үүдсэн зардлын шалтгаантай хүчин зүйлсийн нөлөө өндөр байлаа.

Зураг I.1

Инфляц




Эх сурвалж: УСХ

Харин 8 дугаар сард жилийн инфляц улсын хэмжээнд 14.4 хувь, Улаанбаатар хотод 14.8 хувьд хүрч 2 сар дараалан буурлаа (Зураг I.1). Тайлант сарын Улаанбаатар хотын инфляцын хөдөлгөөнд гол нөлөө үзүүлсэн бүтээгдэхүүнүүдийг задалж тайлбарлавал:

Махнаас бусад дотоодын хүнсний бүтээгдэхүүний үнэ 8-р сард жилийн 30.7 хувиар өсөж инфляцад үзүүлэх нөлөө 3.1 нэгж хувь болж II улирлаас 0.2 нэгж хувь нэмэгдлээ. Үүнд өндөгний үнэ жилийн 41.0 хувь өссөн нь голлон нөлөөлөв.

Зураг I.2

Инфляц, түүнд хүчтэй нөлөөлсөн бүтээгдэхүүнүүдийн үнийн өсөлт



Эх сурвалж: УСХ, Монголбанк


Үйлчилгээний үнэ тайлант сард жилийн 10.8 хувь өсөж инфляцад үзүүлэх нөлөө 2.3 нэгж хувь буюу II улирлын орчимд байна.

Импортын нийт бараа, бүтээгдэхүүний инфляцад үзүүлэх шууд нөлөө нь тайлант сард 7.2 нэгж хувь буюу инфляцын тал орчим хувийг бүрдүүлэв. Үүнд тээврийн саатлаас үүдэн зардал нэмэгдэж, төгрөгийн ханш суларсан нь гол нөлөөтэй байна (Зураг I.2, I.3). Тухайлбал, 8 дугаар сард шатахуунаас бусад импортын бараа жилийн 11.7 хувь өсөж инфляцын 4.0 нэгж хувийг, импортын хүнс жилийн 29.7 хувиар нэмэгдэж 1.7 нэгж хувийг бүрдүүлжээ. Шатахууны бүлгийн хувьд инфляцад үзүүлэх нөлөө 1.5 нэгж хувь болж II улирлаас 1.1 нэгж хувиар буурсан нь суурь үеийн нөлөө арилсан болон тайлант сард дизель түлшний үнэ литр тутамдаа 300 төгрөгөөр буурсантай холбоотой байв.

¹ Улирлын дундаж инфляц

Зураг I.3

Улаанбаатар хотын жилийн инфляцын бүрэлдэхүүнээр



Эх сурвалж: УСХ, Монголбанк

Төсөөллийн зөрүү

Өмнөх сууриар 2022 оны II улирлын дундаж инфляц 16.1 хувь гарсан нь төсөөллөөс² 0.2 нэгж хувиар өндөр байв. Хүнсний инфляцын хувьд жилийн 19.1 хувь буюу төсөөллийн орчимд байсан бол шатахууны үнэ төсөөллөөс өндөр өссөн нь төсөөллийн зөрүүг голлон тайлбарлаж байна. Тодруулбал, дизель түлшний үнэ зөвхөн II улиралд дунджаар 530 орчим төгрөгөөр нэмэгджээ.

Инфляцын цаашдын төлөв

Өмнөх төсөөлөлтэй харьцуулахад инфляцын төсөөлөл энэ онд буурч, ирэх онд бага зэрэг нэмэгдэхээр байна. Төсөөлөл энэ онд буурахад шатахууны инфляц өмнөх төсөөллөөс буурсан нь голлон нөлөөлөв. Тодруулбал, ОХУ-аас импортлож буй шатахууны хилийн үнэ буурч, дизель түлшний үнэ энэ оны 8 дугаар сард 300 төгрөгөөр хямдарч, АИ-92 шатахууныг он дуустал хөнгөлөлттэй үнээр худалдан авахаар болсон нь инфляцын энэ оны төсөөллийг бууруулж байна. Ирэх онд хүнсний үнийн төсөөлөл нэмэгдэх, гадаад үнэ өсөх, төгрөгийн ханш сулрах холбоотойгоор импортын бараа, үүний дам нөлөөгөөр дотоодын бараа, бүтээгдэхүүний үнэ өсөж, инфляцыг өмнөх төсөөллөөс нэмэгдүүлэхээр байна.

Хүснэгт I.1

Инфляцын төлөвт гарсан өөрчлөлт


Инфляцын богино хугацааны суурь төсөөллийн таамаглал
Өмнөх төсөөлөл 2022Q2-2023Q1 Одоогийн төсөөлөл 2022Q3-2023Q2

Төрөл	Өмнөх төсөөлөл 2022Q2-2023Q1	Одоогийн төсөөлөл 2022Q3-2023Q2
Мах	Махны үнэ гүйцэтгэлтэй уялдан цаашдын төсөөлөл буурлаа. Өмнөх улирлын адил махны нийлүүлэлт тогтвортой байх, малын өвчин гарахгүй байх таамаглалд үндэслэн төсөөллийг боловсруулав.	Махны үнэ гүйцэтгэлтэй уялдан цаашдын төсөөлөл буурлаа. Өмнөх улирлын адил махны нийлүүлэлт тогтвортой байх, малын өвчин гарахгүй байх таамаглалыг авч үзлээ.
Махнаас бусад дотоодын хүнс	Хилийн хязгаарлалт, тээвэр логистикийн нөхцөл байдал сайжраагүйн дээр төгрөгийн ханш суларсан зэрэг нь импортын орцын үнийг өсгөх замаар махнаас бусад дотоодын хүнсний үнийг нэмэгдүүлж байна. Гадаад төлөв байдлаас шалтгаалан төсөөллийг нэмэгдүүлэв.	Төсөөлөл нэмэгдсэн Махнаас бусад хүнсний үнэ өмнөх төсөөллөөс өндөр байгаагийн зэрэгцээ худалдааны түнш орнуудын инфляц эрчтэй нэмэгдсэн, ханш суларсан зэргээс импортын орцын үнийг нэмэгдүүлж байна.
Импорт (шатахууныг хассан)	Тээвэр логистик, гадаад орчны нөхцөл байдлын цаашдын хандлага өмнөх улирлын төсөөллөөс өөрчлөгдөөгүй учир импортын үнийн төсөөлөл хэвэндээ байна.	Төсөөлөл хэвэндээ Тээвэр логистик, гадаад орчны нөхцөл байдлын цаашдын хандлага өмнөх улирлын төсөөллөөс өөрчлөгдөөгүй учир импортын инфляцын төсөөлөл хэвэндээ байна.
Дотоодын бараа	Сайжруулсан түлшний үнийн хөнгөлөлт 4-р сард зогссон. Цаашид үндсэн үнээрээ худалдаалагдана.	Төсөөлөл хэвэндээ Дотоодын барааны үнийн өсөлт өмнөх улирлын төсөөлөлтэй нийцтэй байна.
Төрийн зохицуулалттай үйлчилгээ	Төрийн зохицуулалттай үйлчилгээний үнэд өөрчлөлт орохгүй.	Төсөөлөл нэмэгдсэн Хот хоорондын зорчигч тээврийн төлбөр өссөн нөлөөгөөр төсөөлөл нэмэгдлээ. Цаашид үнэ өөрчлөгдөхгүй байх таамаглалыг төсөөлөлд тусгав.
Шатахуун	Газрын тосны үнэ өндөр байгаа хэдий ч цаашдын төсөөлөл өмнөх улирлаас буурсан. Тухайлбал, "Зарим төрлийн бүтээгдэхүүний хангамжийг нэмэгдүүлэх үнийг тогтвортой байлгах тухай хууль" батлагдсанаар А-92 төрлийн шатахууны үнэ тогтвортой байгаагаас шатахууны үнэ нэмэгдэх хэмжээ өмнөх төсөөллөөс багаслаа.	Төсөөлөл буурсан АИ-92 шатахууныг он дуустал хөнгөлөлттэй үнээр авах хэлцэлээр хийгдсэнтэй холбоотойгоор шатахууны үнийн төсөөлөл буурлаа.

Эх сурвалж: Монголбанк

Зураг I.4

Инфляцын төсөөлөл



Эх сурвалж: Монголбанк

² Өмнөх сууриар тооцсон 2022 оны 5 дугаар сарын төсөөлөл

Ирэх улирлуудад махны үнэ улирлын хандлагаа даган буурах бол тээвэр, үйлдвэрлэлийн зардлын өсөлттэй холбоотойгоор хүнсний үнэ нэмэгдэх хандлага үргэлжлэхээр авч үзлээ. Түүнчлэн, тээвэр, логистикт үүссэн хүндрэл энэ онд сайжирч, хэвийн түвшинд очихооргүй байгаагаас зардлын болон нийлүүлэлтийн шалтгаантай инфляц эрчимжих хандлага ирэх улирлуудад хадгалагдах төлөвтэй байна.

Хүснэгт I.2

Инфляцын төсөөлөл

	2021	2022*	2023*	2024*
		<i>төсөөлөл</i>		
Инфляц ³	11.4	13.6 [12.1-14.9] ⁴	7.8 [5.0-10.2]	6.3 [4.2-8.2]

Эх сурвалж: Монголбанк

Дунд хугацаанд уул уурхайн бус салбарын өсөлт удааширч, эрэлтийн шалтгаантай инфляцын дарамт багасах хэдий ч ханш сулрах, гадаад үнэ өсөх зэрэг гадаад хүчин зүйлсийн нөлөөгөөр инфляцын төсөөлөл нэмэгдэж, улмаар Төв банкны зорилтот интервалд тогтворжих хугацаа хойшлох хандлагатай боллоо. Инфляцыг дунд хугацаанд тогтворжуулах, банкны системийн эх үүсвэрийн долларжилт нэмэгдэж, гадаад суурь хүү өсч байгаа нөхцөлд төгрөгийн өгөөжийг нэмэгдүүлэх зорилгоор Монголбанкны Мөнгөний бодлогын хороо 9 дүгээр сарын ээлжит хурлаар бодлогын хүүг нэмэгдүүлж, хүүгийн коридорыг өргөтгөн мөнгөний бодлогын төлөвийг хатууруулж байгаа нь инфляцын дараа үеийн нөлөө болон хүлээлтийг тогтворжуулахад дэмжлэг үзүүлнэ.

Инфляцын төсөөллийг өөрчилж болзошгүй тодорхой бус байдал:

Эрсдэл, тодорхой бус байдал	Магадлал	Нөлөө
Бараа бүтээгдэхүүн, түүхий эдийн нийлүүлэлтийн доголдлын нөхцөл байдал төсөөлөлд авч үзсэнээс өөрчлөгдөх, төрийн зохицуулалттай бараа үйлчилгээний үнэ өөрчлөгдөх зэрэг нь инфляцын төсөөллийг өөрчлөх шалтгаан болно.	Дунд	Өндөр (өсгөх)

Эрсдэл, тодорхой бус байдал	Магадлал	Нөлөө
Олон улсын харилцаанд үүсээд буй нөхцөл байдлаас үүдэн төлбөр тооцоо удаашрах, улмаар манай орны хойд хилээр орж ирэх импорт саатан инфляцыг эрчимжүүлэх эрсдэлтэй.	Өндөр	Дунд (өсгөх)
Олон улсын тээвэр, логистикийн түгжрэл, манай орны хилийн бүс дэх хязгаарлалт, түүний хэвийн горимд орох хугацаа тодорхой бус хэвээр байна. Энэхүү нөхцөл байдал нь гадаад худалдааны тээвэрлэлтийн хугацаа удаашрах, тээврийн зардал өсөх, улмаар импортын болон дотоодын бараа бүтээгдэхүүний үнэ өсөх эрсдэлийг бий болгож байна.	Өндөр	Өндөр (өсгөх)
Геополитикийн асуудал илүү хурцдах, улс хоорондын хязгаарлалтууд хэрхэн үргэлжлэх зэргээс үүдэн гадаад орчинд тодорхой бус байдал нэмэгдэх тохиолдолд дэлхийн зах зээл дэх түүхий эдийн үнэ, манай улсыг чиглэх хөрөнгийн урсгалд сөргөөр нөлөөлж, улмаар төгрөгийн ханшид илүү дарамт учруулах, улмаар импортын бараа, бүтээгдэхүүний үнээр дамжин инфляцын хэлбэлзэл бий болох эрсдэлтэй.	Бага-Дунд	Дунд (өсгөх)
Хилийн хязгаарлалт хүлээлтээс удаан үргэлжлэх нь гадаад валютын орох цэвэр урсгалыг бууруулж, төгрөгийн ханш сулрах дарамтыг хүлээлтээс илүү нэмэгдүүлэх нь инфляцын төсөөллийг өсгөж болзошгүй.	Өндөр	Өндөр (өсгөх)
Европын орнуудад эрчим хүчний хямрал бий болж байгаагаас гадаад инфляц хурдтай өсөх, цаашлаад манай улсын импортын бараа, бүтээгдэхүүний үнэ өсөх нөлөөг үзүүлж болзошгүй.	Дунд	Дунд (өсгөх)

Инфляцын гол эрсдэл суурилсан хувилбар төсөөлөл

Инфляц суурь төсөөллөөс өөрчлөгдөж болзошгүй олон тооны эрсдэл байгаа тул инфляцыг өсгөх болон бууруулах гадаад, дотоод хүчин зүйлсийн тохиолдох магадлалыг харгалзан хувилбар төсөөллийг боловсрууллаа. Инфляцыг нэмэгдүүлэх хүчин зүйлсийн хувьд; 1) гадаад инфляц өсөж, бусад Төв банкуудын инфляц зорилтын орчимд тогтворжих хугацаа 2 улирлаар хойшлох, 2) тээврийн үнэ өсөх, 3) газрын тосны үнэ өсөх, 4) дээрх гадаад эрсдэлүүд эдийн засагт бодитой тохиолдвол

³ ХҮИ-ээр хэмжигдэх инфляц, 4 дүгээр улирлын дундаж

⁴ 30 хувийн магадлалтай итгэх интервал

банкны эх үүсвэр буурч, ирэх онд зээлийн хэмжээ өсөхгүй байх, 5) нэрлэсэн цалин өсөх, 6) төсвийн зардал тэлэх гэсэн таамаглалд үндэслэв. Харин инфляцыг бууруулах хүчин зүйлсийн хувьд дээрх эрсдэлүүд суурь төсөөлөлд авч үзсэнээс буурах тохиолдлын илрэх магадлалыг харгалзан ялгаатай авч үзлээ. Хувилбар төсөөллийг боловсруулахдаа дээрх таамаглалт нөхцөлүүдийг дэс дараалан нэмэх байдлаар тооцов. Таамаглалд авч үзсэн нөхцөлүүдийн дэлгэрэнгүйг Хүснэгт I.3-т харууллаа.

Хүснэгт I.3

Инфляцыг өсгөх гадаад, дотоод хүчин зүйлс		
1	Гадаад үнэ өсөх	Гадаад инфляц Төв банкны зорилтот тогтворжих хугацаа 2 улирлаар хойшилж, импортын бараа, бүтээгдэхүүний үнэ суурь төсөөллөөс илүү өсөх
2	Тээврийн үнэ өсөх	Тээврийн үнэ инфляцын 18 орчим хувийг эзэлж байгаа бөгөөд тээврийн үнэ энэ оны сүүлээс өссөнөөр нийт инфляцын 24 хувийг эзэлж, инфляцын дарамт нэмэгдэх
3	Газрын тосны үнэ өсөх	АИ-92 шатахууны үнийг хямдралтай үнээр худалдан авах гэрээ дуусгавар болохын зэрэгцээ газрын тосны зах зээл дэх эрэлт, нийлүүлэлтийн тэнцвэргүй байдал үргэлжилж, газрын тосны үнэ ирэх онд 30 хувиар өсөх
4	Дээрх гадаад эрсдэлүүд эдийн засагт бодитой тохиолдвол банкны эх үүсвэр буурч, ирэх онд зээлийн хэмжээ өсөхгүй байх	Гадаад эрсдэл нэмэгдэж, төлбөрийн тэнцлийн алдагдал тэлэх тохиолдолд банкны эх үүсвэр буурч, зээлийн өсөлт ирэх онд тэг хувь болж суурь төсөөллөөс буурах
5	Нэрлэсэн цалин өсөх	Инфляц өсөж, бодит орлого буурсантай холбоотойгоор цалин өсөх дарамт нэмэгдэн, ирэх оны эхнээс цалин 30 хувиар өсөх
6	Төсвийн зардал тэлэх	Төсвийн зардал тэлж, 2023 онд төсвийн зардлын ДНБ-д эзлэх хувь 38 хувь, 2024 онд 34 хувьд хүрэх
Инфляцыг бууруулах гадаад, дотоод хүчин зүйлс		
1	Гадаад үнэ буурах	Гадаад инфляц Төв банкны зорилтот тогтворжих хугацаа 1 улирлаар наашилж, импортын бараа, бүтээгдэхүүний үнэ суурь төсөөллөөс буурах

2	Тээврийн үнэ буурах	Тээврийн үнэ өсөхтэй адил хэмжээгээр тээврийн үнэ буурч, инфляцын дарамт багасах
3	Шатахууны үнэ хэвээр хадгалагдах	АИ-92 шатахууныг он дуустал хөнгөлөлттэй үнээр худалдан авах гэрээ амжилттай сунгагдаж, ирэх оны 1 дүгээр улирал дуустал шатахууны үнэ хэвээр хадгалагдах
4	Төсвийн зардал буурах	Төсвийн зардал буурч, 2023-2024 онд төсвийн зардлын ДНБ-д эзлэх хувь харгалзан 30 хувьд хүрэх

Эх сурвалж: ОУВС (2022 оны 7 сар), Дэлхийн банк (2022 оны 6 сар)-ны тайлан

Инфляц нэмэгдэх хувилбар төсөөлөл:

Гадаад инфляц өсвөл нэг талаас импортын бараа, бүтээгдэхүүний үнэ, нөгөө талаас гадаад суурь хүү өсөж, төгрөгийн ханш суларч инфляц нэмэгдэхэд нөлөөлнө. Үүнтэй зэрэгцээд тээврийн зардал өсөх нь импортын бараа, бүтээгдэхүүний үнэ нэмэгдэх, тээвэр, үйлдвэрлэлийн зардлаар дамжин дотоодын бараа, бүтээгдэхүүний үнэ өсөх нөлөөг үзүүлнэ. Гадаад үнэ, тээврийн зардал нэмэгдэхтэй зэрэгцэн ирэх оноос АИ-92 шатахууныг хөнгөлөлттэй үнээр авах хэлэлцээр дуусгавар болвол газрын тосны үнэ 30 хувиар өсөх тохиолдолд шатахууны инфляц огцом нэмэгдэх бөгөөд үүний дам нөлөө бусад бараа, бүтээгдэхүүний үнэд хүчтэй ажиглагдана. Ялангуяа, тээвэр, үйлдвэрлэлийн зардал өсөж, зардлын инфляцаар дамжин дотоодын бараа, бүтээгдэхүүний үнэ өсөх нөлөө үзүүлнэ. Түүнчлэн, газрын тосны үнэ өссөнтэй холбоотойгоор импортын төлбөрүүд нэмэгдэж, ханш сулрах дарамт нэмэгдэх тул импортын барааны үнээр дамжин инфляц хурдтай нэмэгдэнэ. Ийнхүү дээрх гадаад эрсдэлүүд зэрэг тохиолдох нөхцөлд төлбөрийн тэнцлийн алдагдал тэлж, улмаар банкны эх үүсвэр буурч, зээлийн хэмжээ ирэх онд нэмэгдэхгүй байх хувилбарыг авч үзэв. Энэ үед эдийн засгийн өсөлт хурдтай саарч, эрэлтийн шалтгаантай инфляц хумигдах юм. Нөгөө талаас, эдийн засагт төгрөгийн нийлүүлэлт багасах тул ханш

бага зэрэг чангарч, инфляцын дарамтыг бууруулна.


Үүнтэй зэрэгцээд нэрлэсэн цалинг өсгөх нь орлогын өсөлтийн нөлөөгөөр эрэлтийн инфляцыг өдөөж, инфляц илүү хурдтай нэмэгдэх эрсдэл үүсэж болзошгүй. Хэдийгээр нэрлэсэн цалин өссөнөөр хэрэглээ нэмэгдэх ч, үүнийг дагаад инфляц өсөж бодит дүнгээр хэрэглээг төдийлөн өсгөх нөлөө үзүүлэхгүй байх эрсдэл өндөр тул эдийн засгийн өсөлтийг дэмжих нөлөө бага юм. Дунд хугацаандаа цалин өсөж, үйлдвэрлэлийн зардал (хөдөлмөрийн бүтээмж нэмэгдэхгүй гэж үзвэл) нэмэгдсэнээр эдийн засгийн өсөлтийг сааруулна. Цалин өсөх, хөрөнгө оруулалтын зардал нэмэгдэн төсвийн нийт зардал төсвийн хүрээний мэдэгдлээс нэмэгдэж батлагдах эрсдэл өндөр тул үүнийг инфляцыг өсгөх нэг эрсдэлт хүчин зүйлсээр авч үзлээ. Энэ тохиолдолд хөрөнгө оруулалтууд нэмэгдэж, эдийн засгийн өсөлтийг тэтгэх хэдий ч импорт өсөж, ханш сулрах дарамтыг нэмэгдүүлнэ. Энэ үед инфляц эрэлт болон ханшийн аль алианаар нь өдөөгдөж, хурдтай нэмэгдэнэ. Энэ нь бодлогын хүүг илүү ихээр, хурдтай өсгөх шаардлагыг үүсгэнэ.

Инфляцыг өсгөх эрсдэлт хүчин зүйлсээс гадаад үнэ өсөх, тээврийн зардал нэмэгдэх нь богино хугацаанд илрэн эргээд инфляц жил орчмын дараагаас буурч, суурь төсөөллийн орчимд тогтворжиж байгаа бол шатахууны үнэ өсөх, цалин нэмэгдэх, төсвийн зардал тэлэх нөлөө илүү удаан хугацаанд инфляцыг нэмэгдүүлж, Төв банкны зорилтод тогтворжих хугацааг жил

орчмоор хойшлуулж байна. Ялангуяа, шатахууны үнэ нь зардлын инфляц, ханшийн нөлөөгөөр дамжин үнэд нөлөөлдөг тул инфляцыг өсгөх нөлөө хүчтэй юм. Түүнчлэн, төсвийн зардлын шок нь эрэлтийн инфляцыг өдөөх, ханшаар дамжин импортын үнийг нэмэгдүүлэх зэргээр инфляцыг өсгөх нөлөө нь хамгийн урт хугацаанд үргэлжилж байна. Ийнхүү дээрх эрсдэлт хүчин зүйлс зэрэг тохиолдох нөхцөлд инфляц ирэх онд 19 орчим хувьд хүрч, 2024 оноос алгуур бууран 2025 оны эхний улирлаас зорилтын дээд интервалд тогтворжиж байна. Төгрөгийн ханш сулрах дарамт хурдтай нэмэгдэж, 2023-2024 онуудад суурь төсөөллөөс 250-450 орчим төгрөгөөр сул тогтох төсөөлөлтэй ба энэ үед бодлогын хүү 17 хувьд хүрч өсөх шаардлага үүснэ. Гадаад үнэ өсөх, тээврийн зардал нэмэгдэхэд эдийн засгийн өсөлт бага зэрэг саарч, шатахууны үнэ нэмэгдсэнээр нэг талаас худалдааны нөхцөл муудах, нөгөө талаас үйлдвэрлэлийн зардал өсөж, эдийн засгийн өсөлт 2023 онд 3.8 хувьд хүрч буурна. Ингээд зээлийн тасалдалтай холбоотойгоор эдийн засгийн өсөлт хурдтай саарч, 1.7 хувьд хүрэх тооцоолол гарч байна. Үүний дараа нэрлэсэн цалин өсөх нь хэрэглээг дэмжих ч, энэ нь эргээд инфляцыг өсгөн бодит орлогыг төдийлөн нэмэгдүүлэхгүй тул эдийн засгийн өсөлтөд үзүүлэх нөлөө бага юм. Харин төсвийн зардал тэлснээр эдийн засгийн өсөлт 3.4 хувьд хүрч богино хугацаандаа үйлдвэрлэлийг дэмжих хэдий ч, энэхүү нөлөө нь дунд хугацаандаа өндөр инфляц, төгрөгийн ханшийн сулралыг бий болгож, үйлдвэрлэлийн зөрүү хаагдах хугацааг улам бүр хойшлуулах юм.

Зураг I.5

Инфляцын эрсдэлд суурилсан хувилбар төсөөлөл

**Инфляц буурах хувилбар төсөөлөл:**


Инфляцыг бууруулах хүчин зүйлсээр 1) гадаад үнэ буурах, 2) тээврийн зардал буурах, 3) шатахууны үнийн хөнгөлөлт үргэлжлэх, 4) төсвийн зардал буурах гэсэн таамаглалт нөхцөлүүдийг ашиглалаа. Бусад төв банкууд мөнгөний бодлогын төлөвөө хүлээлтээс илүү хурдтай хатууруулах бодлого хэрэгжүүлж эхэлсэн, тээврийн саатал алгуур арилж, олон улсын тээврийн үнийн индекс буурч байгаа болон газрын тосны үнэ гадаад ихэнх төсөөллөөс бага байгаа, цаашид буурах төсөөллийг зарим гадаад эх сурвалжууд хийж байгаа зэрэг нь гадаад инфляц буурах, тээврийн үнэ буурах болон шатахууны үнийг бууруулах хувилбар төсөөллийг боловсруулах үндэслэл болж байна. Харин төсвийн зардал буурах нөлөөг хэмжих, харьцуулах зорилгоор төсвийн зардал буурах хувилбарыг авч үзлээ. Гадаад үнэ, тээврийн үнэ буурах нөлөөгөөр инфляц богино хугацаанд буурч эргээд тогтворжих нөлөөг үзүүлж байгаа бол төсвийн зардал буурах нь инфляцад хамгийн хүчтэй нөлөөг үзүүлж байна. Учир нь төсвийн зардал буурснаар дунд хугацаандаа инфляцад нөлөөлөх эрэлтийн болон зардлын нөлөө буурахын зэрэгцээ төгрөгийн ханш сулрах дарамт багасах юм. Ийнхүү төсвийн зардал буурч,

нийлүүлэлтийн шинжтэй аливаа дарамтууд арилсан, гадаад эрсдэлүүд саарах нөхцөлд инфляц буурч, төгрөгийн ханшид ирэх дарамт багасах бөгөөд энэ үед мөнгөний бодлогын орон зай нэмэгдэн бодлогын хүүг бууруулах боломж бүрдэх юм.

Эдийн засгийн өсөлтийн төсөөллийн хувьд гадаад үнэ, тээврийн үнэ өсөх зэрэг нь бага хэмжээний бууруулах нөлөөтэй бол банкуудын зээл олголт хумигдах нь хамгийн том сөрөг нөлөөг үзүүлж байна. Ирэх онд банкуудын зээлийн хэмжээ өсөхгүй гэж үзвэл эдийн засгийн өсөлтийг 2.1 нэгж хувиар бууруулж, уул уурхайн бус салбаруудын үйл ажиллагаа эрчтэй хумигдах нөлөөг үзүүлэхээр байна. Үүнээс гадна, төсвийн зардал нэмэгдэх нь дотоод эрэлтийг тэтгэж байгаа ч инфляцыг өдөөж, ханш сулрах дарамтыг нэмэгдүүлэх давхар хор уршигтай байна.

Зураг I.6

Инфляцын эрсдэлд суурилсан хувилбар төсөөлөл



*4 улирлын нийлбэр бодит ДНБ-ий жилийн өсөлт
Эх сурвалж: Монголбанк

Хүснэгт I.3 Инфляцын эрсдэлд суурилсан хувилбар төсөөллүүд

Хувилбар ууд	Авч үзсэн нөхцөлүүд	Эдийн засгийн өсөлт				Инфляц**			
		2021	2022*	2023*	2024*	2021	2022*	2023*	2024*
Суурь	Суурь төсөөлөл	1.6	3.0	4.4	6.1	11.4	13.6	7.8	6.3
Инфляци өсөх хувилбар	X2.1 (1) Гадаад үнэ өсөх	1.6	3.0	4.2	6.3	11.4	13.9	8.6	6.5
	X2.2 2. (1) + Тээврийн үнэ өсөх	1.6	3.0	3.9	6.4	11.4	14.7	10.2	6.3
	X2.3 3. (2) + Газрын тосны үнэ өсөх	1.6	3.0	3.8	5.8	11.4	14.7	14.2	6.5
	X2.4 4. (3) + Зээл зогсох	1.6	3.0	1.7	7.4	11.4	14.7	12.9	5.9
	X2.5 5. (4) + Цалин өсөх	1.6	3.0	1.7	6.2	11.4	14.8	15.5	6.9
	X2.6 6. (5) + Төсвийн зардал тэлэх	1.6	3.0	3.4	5.7	11.4	14.9	17.9	8.8
Инфляци буурах	X3.1 (1) Гадаад үнэ буурах	1.6	3.0	4.5	6.1	11.4	13.5	7.5	6.3
	X3.2 2. (1) + Тээврийн үнэ буурах	1.6	3.0	4.6	6.4	11.4	12.5	5.9	6.2
	X3.3 3. (2) + Шатахууны хөнгөлөлт үргэлжлэх	1.6	3.0	4.6	6.6	11.4	12.5	5.1	6.2
	X3.4 4. (3) + Төсвийн зардал буурах	1.6	3.0	2.8	7.1	11.4	12.5	3.1	4.7

** Он тус бүрийн 4 дүгээр улирлын дундаж инфляци
Эх сурвалж: Монголбанк

II. ЭДИЙН ЗАСГИЙН ӨСӨЛТ


Эдийн засаг оны эхний хагас жилд 1.9 хувийн өсөлттэй гарлаа. Үүнд хөл хорионы дэглэм суларч, төсөв, мөнгө, санхүүгийн бодлогын арга хэмжээ үр дүнгээ өгч дотоод эрэлт⁵ сэргэн, уул уурхай, тээврээс бусад салбарууд өссөн нь нөлөөллөө.

Нийт эрэлт

Оны I улиралд 3.8 хувиар агшаад байсан нийт эрэлт II улиралд 6.9 хувиар тэллээ. Эрэлт ийнхүү тэлэхэд эцсийн хэрэглээ, хөрөнгийн нийт хуримтлал эергээр нөлөөлсөн бол цэвэр экспорт бууруулах нөлөө үзүүлсэн хэвээр байна (Зураг II.1).

Зураг II.1

Эцсийн хэрэглээ болон хөрөнгийн нийт хуримтлал II улиралд 24.9 хувиар тэлэв.



Эх сурвалж: YCX


Нийт эрэлтийн II улирлын гүйцэтгэлийг бүрэлдэхүүн бүрээр дэлгэрүүлж тайлбарлавал:

Өрхийн хэрэглээ II улиралд үргэлжлэн эрчимжиж өмнөх оны мөн үеэс 5.1 хувь, цар тахлын өмнөх⁶ үеэс 3.9 хувиар давлаа. 2021 оны дунд үеэс хөдөлмөрийн зах зээл эргэн сэргэж, өрхийн орлогын гол эх үүсвэр болох өрхийн цалингийн орлого нэмэгдсэн⁷ нь хэрэглээг дэмжиж байна (Зураг II.2). Үүнтэй

зэрэгцэн хөл хорионы улмаас өнгөрсөн 2 жилийн хугацаанд ихээр агшсан үйлчилгээ болон зарим төрлийн импортын барааны хэрэглээ нэмэгдэж эхэлсэн нь өрхийн хэрэглээний өсөлтөд том нөлөөтэй байна. Түүнчлэн, Засгийн газрын хэрэглээ тайлант улиралд жилийн 5.8 хувиар өсөж, нийт эрэлтэд 1.0 нэгж хувийн эерэг нөлөө үзүүлэв.

Зураг II.2

Хувийн хэрэглээ үргэлжлэн сэргэж байна.



Эх сурвалж: YCX, Монголбанк

Хөрөнгийн нийт хуримтлалын хувьд II улиралд 61.7 хувиар өссөн байна (Зураг II.3). Өсөлтийн багагүй хувийг импортоор авч буй том оврын машин, тоног төхөөрөмж, суудлын автомашин бүрдүүлсэн бол мал төллөлт энэ оны II улирлын байдлаар түүхэн дээд хэмжээнд хүрсэн нь хөрөнгийн нийт хуримтлалын өсөлтөд том нөлөөтэй байлаа.


⁵ Эцсийн хэрэглээ болон хөрөнгийн нийт хуримтлалын нийлбэр

⁶ Ковид-19 цар тахал Монгол улсад анх бүртгэгдэхээс өмнөх буюу 2019 оныг ашиглав.

⁷ Өрхийн сарын дундаж орлого дахь цалингийн орлогын хэмжээ 2022 оны II улиралд жилийн 27.5 хувь, ХҮИ-ээр засварласан бодит дүнгээр 9.8 хувиар өсчээ.

Зураг II.3

Хөрөнгийн нийт хуримтлал өссөн хэвээр байна.




Эх сурвалж: УСХ, Монголбанк

Экспорт алгуур сэргэж байгаа нь нийт эрэлтэд эерэг нөлөө үзүүлж байна. Тухайлбал, энэ оны II улиралд экспортолсон нүүрсний биет хэмжээ жилийн 110 хувь, зэсийн баяжмалын хэмжээ жилийн 56 хувиар өссөн бол 6-р сараас боловсруулаагүй нефть экспортолж эхэллээ. Нөгөөтэйгүүр манай улс руу гуравдагч орноос ирэх импортын дийлэнхийг дамжуулан өнгөрүүлдэг БНХАУ-ын Тяньжин боомтоос татан авах чингэлгийн тоог II улирлын дунд үеэс нэмэгдүүлснээр импортын барааны эргэлт хурдасч, тайлант улиралд импорт бодит дүнгээр жилийн 34 хувиар өсөв (Зураг II.4).

Зураг II.4

Нүүрсний экспорт өнгөрсөн улирлаас нэмэгдэв.




Эх сурвалж: УСХ

Нийт нийлүүлэлт

Нийт нийлүүлэлт энэ оны эхний хагас жилд 2021 оны мөн үеэс 1.9 хувиар тэлсэн ч цар тахлын өмнөх үетэй⁸ харьцуулахад 1.4 хувиар бага байна. Энэ нь голчлон уул уурхайн салбарын үйлдвэрлэл хэвийн түвшиндээ хүрч хараахан сэргээгүй байгаатай холбоотой байна. Харин уул уурхайн бус салбаруудын хувьд үйлдвэрлэл цар тахлын өмнөх үеийн түвшнээс 5.2 хувиар давжээ (Зураг II.5). Энэ оны II улирлын хувьд нийт нийлүүлэлтийн жилийн өсөлт эрчимжиж, 6.3 хувьд хүрсэн бөгөөд эдийн засгийн үйл ажиллагааны ихэнх салбаруудад өсөлт ажиглагдлаа. Салбар тус бүрээр II улирлын гүйцэтгэлийг авч үзвэл:

Зураг II.5

Уул уурхайн бус салбаруудын идэвхжил цар тахлын өмнөх түвшинд хүрчээ.



Эх сурвалж: УСХ, Монголбанк

Хөдөө аж ахуйн салбарын өсөлт эрчимжиж 11.3 хувьд хүрсэн нь энэ оны мал төллөлт, төл бойжилтийн явц олон жилийн дунджаас өндөр гүйцэтгэлтэй байгаагийн зэрэгцээ том малын зүй бус хорогдол бага байгаагаар голлон тайлбарлагдаж байна. Газар тариалангийн салбарын хувьд дотоодын улаанбуудай, төмсний хэрэгцээг бүрэн, хүнсний ногооны хэрэгцээг 70 хувьтай хангах хэмжээний ургац авахаар урьдчилсан тооцоо ХХААХҮЯ-наас гарчээ.


⁸ 2019 оны эхний хагас жил

Худалдааны салбар 16.1 хувиар, үүнтэй уялдаатайгаар бараа, бүтээгдэхүүнд ногдуулсан татварын орлого 13.6 хувиар тус тус тэллээ. Энэ нь тайлант улиралд чингэлэг татан авалт сайжирч, импортын барааны эргэлт хурдассантай шууд холбогдож байна. Тодруулбал, удаан эдэлгээт хэрэглээний бараа болон барилгын материалын импорт, борлуулалт сайжирчээ.

Үйлчилгээний салбаруудын өсөлт тайлант улиралд 5.4 хувьтай байлаа. Үүнд өмнөх оны мөн үед хатуу хөл хорионы улмаас идэвхжил нь огцом хумигдаад байсан байр сууц, хоол хүнсээр үйлчлэх, урлаг үзвэрийн холбогдолтой дэд салбарууд сэргэснээр голлох нөлөөг үзүүлжээ. Харин сүүлийн саруудад зээл, хадгаламжийн өсөлт удааширч байгаа нь санхүү даатгалын холбогдолтой үйл ажиллагааг сааруулж байна. Түүнчлэн, үл хөдлөх хөрөнгийн үйл ажиллагаа он гарсаар төдийлөн сэргээгүй байна.

Зураг II.6

Уул уурхай, тэвэрээс бусад салбарууд өслөө.



Эх сурвалж: YCX


Сүүлийн 3 улирал дараалан уналттай байсан боловсруулах салбар тайлант улиралд 5.0 хувиар өслөө. Энэ нь өмнөх улирлуудтай харьцуулбал хилийн боомтууд дээрх асуудал алгуур сайжирч, дотоодын боловсруулах үйлдвэрлэлд шаардагдах түүхий эд, бараа материалын татан авалт дээрдэж байгаатай холбоотой байж болох

юм. Голлох бүтээгдэхүүнээр авч үзвэл ундаа, нэхмэл бүтээгдэхүүн, барилгын материал үйлдвэрлэл өсөлттэй байгаа бол мах, сүү, гурил, шахмал түлш болон химийн гаралтай эм, эмэн бүтээгдэхүүний үйлдвэрлэл саарчээ.

Харин сүүлийн 8 улирлын турш тогтмол уналттай байсан барилгын салбар тайлант улиралд 1.7 хувиар өсжээ. Үүнд орон сууцны болон сургууль соёл, дотуур байрны зэрэг орон сууцны бус зориулалттай барилгын ажлууд эерэг нөлөө үзүүллээ. Мөн авто зам болон төмөр зам зэрэг инженерийн барилга байгууламжийн ажил идэвхжих хандлагатай болж байна.

Зураг II.7

Уул уурхайн үйлдвэрлэл уналттай хэвээр байна.



Эх сурвалж: YCX, Монголбанк

Уул уурхайн салбар тайлант улиралд 18.2 хувиар, үүнтэй холбогдуулан тээврийн салбар 8.7 хувиар тус тус агшлаа. Өнгөрсөн оны сүүлийн хагасаас хойш хилийн боомтууд дээр үүссэн асуудлаас шалтгаалан эдгээр салбарууд уналттай гарч байгаа билээ. Уул уурхайн голлох нэр төрлийн бүтээгдэхүүнээс нүүрсний тээвэрлэлт 5-р сараас эхлэн сэргэх хандлагатай болсон бол оны эхнээс хойш зогсонги байсан газрын тосны тээвэрлэлт 6-р сараас сэргэж эхэллээ. Оюу толгойн уурхайгаас олборлож буй зэсийн агууламж болон түүнд агуулагдах алт энэ онд төлөвлөгөөний дагуу буурч байна (Зураг II.7).

Хүснэгт II.1.2

Эдийн засгийн өсөлтийн төлөвт гарсан өөрчлөлт (2022)

НИЙТ ЭРЭЛТ	
Эцсийн хэрэглээ	Өмнөх төсөөллийн орчимд
<ul style="list-style-type: none"> Хөдөлмөрийн зах зээл, иргэдийн хөдөлгөөнт байдал сайжрах, хэрэглээний бүтээгдэхүүний импорт нэмэгдэхтэй уялдан өрхийн хэрэглээ сэргэж буй хандлага он дуустал үргэлжлэхээр байна. 	
Хөрөнгийн нийт хуримтлал	Өмнөх төсөөллөөс нэмэгдсэн
<ul style="list-style-type: none"> Төсвийн хөрөнгө оруулалт, бизнесийн зээл олголт удаан хэвээр байгаа хэдий ч импортын барааны татан авалт II улиралд хүлээлтээс давсан нь хөрөнгө оруулалтын бүтээгдэхүүн, эргэлтийн хөрөнгийн хуримтлалд эерэгээр нөлөөлж байна. 	
Экспорт	Өмнөх төсөөллийн орчимд
<ul style="list-style-type: none"> Уул уурхайн бүтээгдэхүүний экспортын биет хэмжээ оны сүүлийн хагаст нэмэгдэх, өнгөрсөн оны мөн үеийн түвшинд хүрэх тооцоололтой байна. 	
НИЙТ НИЙЛҮҮЛЭЛТ	
Уул уурхай	Өмнөх төсөөллөөс нэмэгдсэн
<ul style="list-style-type: none"> Уул уурхайн голлох бүтээгдэхүүний экспортын тээвэрлэлт, хилийн боомтуудаар нэвтрэх чадамж өмнөх улирлаас сайжирсан тул тус салбарын төлөвийг бага зэрэг сайжрууллаа. 	
Уул уурхайн бус	Өмнөх төсөөллөөс нэмэгдсэн
<ul style="list-style-type: none"> Цаг агаарын нөхцөл байдал таатай үргэлжилсэн тохиолдолд ХАА-н салбарын өсөлт энэ онд өндөр хадгалагдахаар байна. Хөдөлмөрийн зах зээлийн үндсэн үзүүлэлтүүд эерэг байгаа нь ажиллах хүч ихээр шингээдэг уул уурхайн бус салбаруудын төлөвийг сайжруулж байна. Уул уурхайн салбарын төлөв сайжирч байгаагаар холбогдуулан тээврийн салбарын төлөв нэмэгдлээ. Харин хадгаламж, зээлийн өсөлт саарч байгаагаар уялдан санхүү даатгалын үйл ажиллагааны төлөв буурч байна. 	


Эх сурвалж: Монголбанк

Потенциал үйлдвэрлэл

КОВИД-19 цар тахал, олон улсад үүссэн геополитикийн хурцадмал нөхцөл байдал зэргийн улмаас дотоод эдийн засгийн идэвхжил хумигдаж, потенциал үйлдвэрлэл 2020 оноос хойш нам дор түвшинд хадгалагдаж байна (Зураг II.7).

Зураг II.7

Потенциал үйлдвэрлэлийн өсөлт




Эх сурвалж: Монголбанк

Эдийн засгийн гол үзүүлэлтүүдийн мэдээллийг ашиглан тооцдог олон хувьсагчийн “Калман фильтр”-ийн тооцооллоор потенциал үйлдвэрлэл алгуур буурсан хэвээр байна. Харин нэг хувьсагчийн HP фильтрийн аргачлалаар тооцсон үйлдвэрлэл 2020 онд сөрөг түвшинд хүрч, 2021 оны эхнээс алгуур нэмэгдэх хандлагатай болж байна. Үйлдвэрлэлийн функцын аргачлалын хувьд хөдөлмөр, бүтээмжийн өсөлт сул байгаагаар холбоотойгоор Калман фильтрийн үр дүнгээс бага түвшинд боловч HP фильтрийн үр дүнгээс өндөр түвшинд байх хандлага хэвээр байна. Ийнхүү эдгээр гурван аргачлалуудаар тооцсон потенциал үйлдвэрлэл сүүлийн улирлуудад 2 орчим хувьд хэлбэлзэж байна.

Үйлдвэрлэлийн зөрүү

КОВИД-19 цар тахлын нөлөөгөөр эдийн засгийн дийлэнх салбаруудын үйл ажиллагаа хумигдаж, үйлдвэрлэлийн зөрүү, ялангуяа уул уурхайн бус үйлдвэрлэлийн зөрүү 2020 оноос хойш тасралтгүй сөрөг түвшинд хадгалагдав. Харин энэ оны эхнээс цар тахлын эсрэг хязгаарлалтууд суларч, дотоод эрэлт сэргэж эхэлснээр худалдаа, үйлчилгээ, үүнийг даган татварын орлогууд нэмэгдэж, уул уурхайн бус салбарын үйлдвэрлэлийн сөрөг зөрүү өмнөх улирлаас багаслаа. Уул уурхайн салбарын хувьд хилийн хязгаарлалтын сөрөг нөлөө үргэлжилсэн хэвээр бөгөөд уул уурхайн үйлдвэрлэлийн зөрүү 2021 оны 2 дугаар улирлаас тайлант улирал хүртэлх хугацаанд уналттай хэвээр байна. (Зураг II.8).

Зураг II.8

Үйлдвэрлэлийн зөрүү⁹

Эх сурвалж: Монголбанк

Эдийн засгийн өсөлтийн цаашдын төлөв

Эдийн засгийн өсөлт 2 дугаар улиралд хүлээлтээс өндөр гарсантай уялдуулан энэ оны өсөлтийн төсөөллийг 3 хувьд хүргэж нэмэгдүүллээ. Уул уурхайн бус салбарт эрчим хүч, боловсруулах, үйлчилгээний зарим салбаруудыг эс тооцвол дийлэнх салбаруудын үйлдвэрлэл өмнөх төсөөллөөс нэмэгдэх хандлагатай байна. Тодруулбал, хөдөө аж ахуй, худалдаа, бүтээгдэхүүний цэвэр татвар зэрэг салбаруудын өсөлт нэмэгдэх хандлага үргэлжлэх бол хилийн хязгаарлалтууд алгуур суларснаар тээвэр, барилгын салбарыг дэмжинэ гэж үзлээ. Харин зээл олголт хумигдсантай холбоотойгоор санхүү, даатгалын үйлчилгээ буурч, үйлчилгээний салбарын өсөлтийн төлөвийг өмнөхөөс бууруулав. Уул уурхайн салбарын хувьд хилийн боомтууд дээрх хязгаарлалтууд суларч, экспорт сэргэж байгаатай холбоотойгоор өсөлтийн төлөв өмнөх төсөөллөөс бага зэрэг сайжрахаар байна.

Дунд хугацаанд уул уурхайн салбарын өсөлт өмнөх төсөөллийн орчимд хадгалагдах бол гадаад эрэлт саарах, худалдааны нөхцөл бага зэрэг муудах, төсвийн төлөв чангарах зэрэг нь уул уурхайн бус салбарын өсөлтийг

удаашруулж, эдийн засгийн өсөлт өмнөх төсөөллөөс буурах хүлээлттэй байна (Зураг II.9).

Зураг II.9

4 улирлын нийлбэр ДНБ-ий жилийн өсөлт



Эх сурвалж: Монголбанк

Уул уурхай: Энэ оны 2 дугаар улиралд алтны олборлолт хүлээлтээс сайн гарсан, Шивээхүрэн, Гашуунсухайт зэрэг боомтын үйл ажиллагаа сүүлийн саруудад сэргэж тээвэрлэлтийн тоо нэмэгдсэн, нүүрс, газрын тосны олборлолт бага зэрэг нэмэгдэж байгаа зэргээс шалтгаалан уул уурхайн салбарын үйлдвэрлэлийг өмнөх төсөөллөөс сайжруулав. Харин дунд хугацаанд Оюу толгойн зэс, түүн доторх алтны агууламж сайжрах, нүүрсний экспорт хэвийн түвшинд хүрэх, газрын тосны олборлолт нэмэгдэх нөлөөгөөр уул уурхайн салбарын өсөлт нэмэгдэхээр байна.

Хүснэгт II.1.1

Эдийн засгийн өсөлтийн төсөөлөл¹⁰

	2021	2022*	2023*	2024*
		<i>төсөөлөл</i>		
ДНБ-ий өсөлт	1.6	3.0 [1.4-4.6]	4.4 [2.0-6.8]	6.1 [3.4-8.9]
Уул уурхайн	0.8	-11.7 [-13.3 - (-10.1)]	10.6 [8.3- 13.0]	5.7 [3.0- 8.5]
Уул уурхайн бус	1.8	5.3 [3.7-6.9]	3.6 [1.3-6.0]	6.1 [3.4-8.9]

Эх сурвалж: Монголбанк

⁹ GAP загварын үр дүн¹⁰ 30 хувийн магадлалтай итгэх интервал

Уул уурхайн бус: Хөдөө аж ахуй, худалдаа, бүтээгдэхүүний цэвэр татвар зэрэг уул уурхайн бус салбарын өсөлтийг тэтгэж буй салбаруудын хандлага ирэх улирлуудад хадгалагдаж, өсөлтийг дэмжихээр байна. Тухайлбал, сүүлийн 3 улирал дараалан өрхийн хэрэглээ өсөж, дотоод эрэлт сэргэж байгаатай холбоотойгоор худалдаа, үйлчилгээний зарим салбарын идэвхжил үргэлжилж, үүнээс улбаалан татварын орлого бүрдүүлэлт нэмэгдэнэ гэж үзлээ. Түүнчлэн, цаг уурын таатай нөхцөл нь ХАА-н салбарын өсөлтөд эерэг нөлөөг үзүүлэх төлөв хэвээр байна. Харин банкуудын зээл олголт хумигдсантай холбоотойгоор санхүү, даатгалын үйлчилгээ буурч, үйлчилгээний салбар оны сүүлийн хагаст удааших төлөвтэй боллоо. Хилийн хязгаарлалт аажмаар суларч байгаа ч ирэх оны эхэн хагас хүртэл үргэлжлэн, тэвэр, барилгын салбарын үйлдвэрлэл энэ онд агших хүлээлт хэвээр байна.

Ирэх онд гадаад эдийн засгийн таагүй байдал үргэлжлэх төлөвтэй байгаагаас гадаад эрэлт саарах, экспортын гол түүхий эдүүдийн үнэ буурснаар гадаад худалдааны нөхцөл муудах, төсвийн төлөв бага зэрэг чангарах зэрэг нь уул уурхайн бус салбарын өсөлтийг сааруулахаар байна.

Эдийн засгийн цаашидын төлөвт нөлөөлж болзошгүй тодорхой бус байдал

Эрсдэл, тодорхой бус байдал	Магадлал	Нөлөө
ОХУ, Украины нөхцөл, байдал нь дэлхийн эдийн засаг, санхүүгийн болон түүхий эдийн зах зээл дэх тодорхой бус байдлын гол эх сурвалж болж байна. Ялангуяа түлш шатахууны үнийн өсөлт, нийлүүлэлтийн сүлжээний доголдол болон санхүүгийн хориг арга хэмжээ зэрэг нь манай улсыг чиглэх хөрөнгийн урсгал, төлбөрийн тэнцэлд сөргөөр нөлөөлөх замаар өсөлтийн төлөвийг муутгах эрсдэлтэй.	Өндөр	Өндөр (сөрөг)
Төлбөрийн тэнцлийн алдагдал тэлсэн, гадаад валютын албан нөөц хурдтай буурсан одоогийн нөхцөлд гадаад сөрөг шокыг шингээх ханшийн тохиргоог хангалттай хэмжээнд хийхгүй байгаа нь гадаад тэнцвэргүй байдлыг улам даамжруулж байна. Гадаад, дотоод тэнцвэр ийнхүү үргэлжлэн алдагдвал спекулятив шинжтэй ханш сулрах эрсдэлийг нэмэгдүүлж, хямралын нөхцөл байдал руу ч хүрч болзошгүй юм.	Дунд	Дунд (сөрөг)
Хилийн бүс дэх импортын хязгаарлалт, барилгын салбарын удаашралтай холбоотойгоор төсвийн төлөвлөгдсөн хөрөнгө оруулалтын нөхцөлд хүндрэл үүсгэх, батлагдсан хөрөнгө оруулалтын ажлууд хойшлогдох, биелэлтэд сөргөөр нөлөөлж, эдийн засгийн төлөвийг бууруулах нөлөө үзүүлэх.	Дунд	Дунд (сөрөг)
Европын орнуудын эдийн засгийн удаашрал, эрчим хүчний хямрал, БНХАУ-ын үл хөдлөх хөрөнгийн салбарын хямрал, улс орнуудын мөнгөний хатуу бодлогын нөлөөгөөр дэлхийн эдийн засаг дунд хугацаанд удааших төлөвтэй байгаа нь гадаад эрэлт, түүхий эдийн үнээр дамжин эдийн засгийн өсөлтийг бууруулах эрсдэлтэй.	Бага	Дунд (сөрөг)
БНХАУ-ын “Тэг-Ковид” бодлогын хүрээнд хилийн удаашрал төсөөлснөөс удаан үргэлжлэх нөхцөлд нийлүүлэлт доголдож, манай гадаад эрэлт буурч, инфляц болон эдийн засгийн өсөлтийн төлөвийг аль алиныг нь муутгах эрсдэлтэй.	Өндөр	Өндөр (сөрөг)
Олон улсад үүссэн хурцадмал нөхцөл байдал, геополитикийн асуудлууд улам даамжирч, дэлхийн эдийн засгийн төлөвт таагүй нөхцөл байдлыг үүсгэж цаашид хэрхэн үргэлжлэх, шийдвэрлэгдэх эсэх нь тодорхой бус байна.	Дунд	Дунд (сөрөг)

III. ДОТООД ЭДИЙН ЗАСГИЙН ОРЧИН

III.1. Хөдөлмөрийн зах зээл

Хөдөлмөрийн захын идэвхжил тайлант улиралд үргэлжлэн сэргэж, дийлэнх үзүүлэлтүүд хэвийн түвшинд дөхөөд байна. Ажиллах хүчнээс гадуурх хүн амаас бүрэн хөдөлмөр эрхлэлт рүү шилжиж байгаа нь хөдөлмөрийн зах зээлд гол эерэг нөлөөг үзүүлж байна (Зураг III.1.1).

Зураг III.1.1


Ажил эрхлэлт нэмэгдэж, ажиллах хүчнээс гадуурх хүн ам буурлаа.



Хөдөлмөрийн зах зээлийн төлөвийг тодорхойлогч үндсэн үзүүлэлтүүдээс ажиллах хүчний оролцооны түвшин 59.3 хувь, хөдөлмөр эрхлэлтийн түвшин 54.7 хувьд хүрсэн нь хойшхи хамгийн өндөр үзүүлэлт боллоо. Түүнчлэн, хөдөлмөрийн дутуу ашиглалтын нийлмэл түвшин¹¹ (11.4 хувь), ажилгүйдлийн түвшин (7.8 хувь) алгуур буурч байна (Зураг III.1.2).

Зураг III.1.2

Хөдөлмөрийн захын үндсэн үзүүлэлтүүд сайжирлаа.




Ажил эрхлэлт, нийгмийн даатгал

Нийт ажил эрхлэлт II улирлын байдлаар өмнөх оны мөн үеэс 5.4 хувиар, үүнээс хөдөө аж ахуйн бус салбаруудын ажил эрхлэлт 7.8 хувиар нэмэгджээ. Тодруулбал, тайлант улиралд өмнөх улирлын хандлагатай нийцтэйгээр боловсруулах, тээвэр, боловсрол, эрүүл мэнд, урлаг үзвэрийн үйлчилгээний салбарт алба хаагчид нэмэгдсэн бол худалдаа, зочлох үйлчилгээ болон хөдөө аж ахуйн салбарт ажиллагчид бага зэрэг буурчээ (Зураг III.1.3).

Зураг III.1.3

Ажиллагчдын өсөлтийг боловсруулах, тээвэр, боловсрол, эрүүл мэндийн салбар бүрдүүлжээ.



¹¹ Энэ нь цаг хугацаанаас хамаарсан бүрэн бус хөдөлмөр эрхлэлт, боломжит ажиллах хүч болон ажилгүйдлийн түвшинг нэгтгэсэн үзүүлэлт юм.

Нийгмийн даатгалд даатгуулагчид 2022 оны эхний 7 сарын байдлаар өмнөх оны мөн үеэс 7.0 хувиар өсөөд байна. Үүнд ажил эрхлэлт эрчимжсэнтэй уялдан албан журмаар төсөвт болон хувийн ААН-үүдээс даатгуулагчдын тоо нэмэгдсэн нь нөлөөлжээ (Зураг III.1.4).

Зураг III.1.4

Нийгмийн даатгалд хамрагдагчид өсч байна.




Эх сурвалж: Нийгмийн даатгалын ерөнхий газар

Нийгмийн даатгалд даатгуулагч нийт ажил эрхлэгчид өмнөх оны мөн үеэс 6.3%-иар өссөн байна. Цалингийн бүлгээр авч үзвэл сард 1.1 саяас дээш цалинтай ажиллагчдын тоо өмнөх оны мөн үеэс эрчтэй нэмэгдэж, харин 1 сая төгрөгөөс доош орлоготой иргэд 12 орчим хувиар буурчээ (Зураг III.1.5).

Зураг III.1.5

Ажиллагчдын өсөлт, цалингийн бүлгээр



Эх сурвалж: Нийгмийн даатгалын ерөнхий газар


Ажилгүйдэл

Энэ оны эхний 7 сарын байдлаар нийгмийн даатгалын сангаас 39.7 тэрбум төгрөгийн ажилгүйдлийн тэтгэмжийг 16.2 мянган хүнд

олгоод байна. Ингэснээр тэтгэмж авч буй нэг иргэнд ногдож буй сарын дундаж ажилгүйдлийн тэтгэмж өмнөх оны мөн үеэс 13 орчим хувиар нэмэгдэж, 2.5 сая төгрөгт хүрлээ (Зураг III.1.6).

Зураг III.1.6

Ажилгүйдлийн тэтгэмж олголт нэмэгджээ.



Эх сурвалж: Нийгмийн даатгалын ерөнхий газар

Цалин, өрхийн орлого

Улсын дундаж цалин тайлант улиралд 1544.4 мянган төгрөг, медиан цалин 1160.2 мянган төгрөг байгаа нь өмнөх оны мөн үеэс 16-17 орчим хувиар нэмэгдсэн үзүүлэлт болж байна. Үүнтэй уялдаатайгаар өрхийн сарын дундаж нийт орлого өмнөх оны мөн үеэс 16 хувиар өсөж, 1787.5 мянган төгрөгт хүрчээ. Ийнхүү нэрлэсэн орлогын үзүүлэлтүүд хэрэглээний үнийн өсөлттэй зэрэгцэж ирснээр дундаж бодит цалингийн индекс тайлант улиралд өмнөх оны мөн үеийн түвшинд хадгалагдсан байна (Зураг III.1.8).

Зураг III.1.8

Бодит цалингийн уналт удааширлаа.



Эх сурвалж: УСХ

Эдийн засгийн голлох салбаруудаас тээвэр (34%), зочлох үйлчилгээ (30%), үл хөдлөх хөрөнгө (23%), худалдаа (21%), санхүү даатгал (20%)-ын салбарт ажиллагчдын дундаж цалин харьцангуй өндөр өсөлттэй байв. Харин төрийн удирдлага (10%), уул уурхай (12%), барилга (12%)-ын салбарт алба хаагчдын цалин харьцангуй бага хувиар өсөв.

Байгууллагуудын хариуцлагын хэлбэрээр авч үзвэл нөхөрлөл (48%), төрийн болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газар (19%), ХХК болон ХК (15-18%)-уудад ажиллагчдын дундаж цалин өмнөх оны мөн үеэс хамгийн ихээр нэмэгджээ.

Нэгж хөдөлмөрийн зардал

Нэгж хөдөлмөрийн зардал¹² сүүлийн улирлуудын дунджаар эргэн нэмэгдэх хандлагатай болж байна. Үүнд цалингийн өсөлт эрчимжиж байгаа нь голлон нөлөөлж байна (Зураг III.1.9).

Зураг III.1.9

Нэгж хөдөлмөрийн дундаж зардал өсч байна.



Эх сурвалж: УСХ

III.2 Мөнгө, санхүүгийн зах зээл

III.2.1 Мөнгө, зээлийн үзүүлэлтүүд


Мөнгөний нийлүүлэлтийн өсөлт буурах хандлага үргэлжлэн, сүүлийн улирлуудад эрчимжиж байсан банкуудын зээлийн өсөлт саарч эхэллээ. Харин банкны системийн

хадгаламжийн долларжилт сүүлийн саруудад нэмэгдэн, зээлийн долларжилт буурах хандлага үргэлжлэв. Банкуудын зээлийн нөхцөл болон шалгуур бага зэрэг чангарсан бол иргэд болон аж ахуйн нэгжүүдийн зээлийн эрэлт нэмэгдсэн байна.

Сүүлийн улирлуудад төлбөрийн тэнцлийн алдагдлаас үүдэн гадаад валютын цэвэр урсгал сөрөг байгаа нь мөнгөний нийлүүлэлтийн өсөлт саарахад голлон нөлөөлсөн хэвээр байна. Харин банкны системийн зээлийн өсөлт мөнгөний нийлүүлэлтийг нэмэгдүүлэх чиглэлд нөлөөлөв. Тухайлбал, мөнгөний нийлүүлэлт 2022 оны 7 дугаар сарын байдлаар өмнөх жилийн мөн үеэс 1.4 хувиар буурахад зээлийн өсөлт 14.6 нэгж хувийн эерэг нөлөө үзүүлсэн бол гадаад цэвэр актив (ГЦА) -20.8 нэгж хувийн бууруулах нөлөөтэй байв (Зураг III.2.1.1). Цаашид төлбөрийн тэнцлийн алдагдал болон зээлийн өсөлт саарч буй нөлөөгөөр мөнгөний нийлүүлэлтийн өсөлт үргэлжлэн алгуур буурч, нам түвшинд хадгалагдах хүлээлттэй байна.

Зураг III.2.1.1

M2 мөнгөний жилийн өсөлтийн бүрэлдэхүүн, актив тал



Эх сурвалж: Монголбанк

Сүүлийн 5 улирлын турш буюу 2021 оны 1 дүгээр улирлаас хойш тасралтгүй эрчимжиж байсан зээлийн өсөлт 2022 оны 2 дугаар улирлаас эхлэн алгуур саарч байна. Түүнчлэн энэ оны 7 дугаар сарын зээлийн сарын өсөлт -0.6 хувьд хүрч, банкны


¹² Нэгж ДНБ-д ногдох дундаж хөдөлмөрийн өртөг буюу цалин.

системийн зээлийн үлдэгдэл өмнөх сараас хумигдлаа.

Энэ оны эхний 7 сард төсвийн шаардлагатай санхүүжилтийн дүн 1.2 их наяд төгрөгт хүрэв¹³. Уг шаардлагатай санхүүжилтийн дийлэнх хэсгийг гадаад зээлээр, үлдсэн хэсгийг Засгийн газрын дотоод үнэт цаас болон банкны систем дэх хуримтлалаас санхүүжүүлэв (Зураг III.2.1.1).

Зураг III.2.1.2

M2 мөнгөний жилийн өсөлтийн бүрэлдэхүүн, пассив тал



Эх сурвалж: Монголбанк


Банкны системийн эх үүсвэр талаас мөнгөний нийлүүлэлт хумигдахад төгрөгийн хадгаламж буурсан нь голлон нөлөөллөө. Тодруулбал, мөнгөний нийлүүлэлт 1.4 хувиар буурахад төгрөгийн хадгаламжийн өсөлт -7.6 нэгж хувь, төгрөгийн харилцахын өсөлт 1.5 нэгж хувь, гадаад валютын харилцахын өсөлт 3.7 нэгж хувь, гадаад валютын хадгаламжийн өсөлт 1.3 нэгж хувийг бүрдүүлэв (Зураг III.2.1.2). Харилцах болон хадгаламжаар нь нэгтгэн авч үзвэл төгрөгийн эх үүсвэр 6.1 нэгж хувиар бууруулах, харин гадаад валютын эх үүсвэр 5.0 нэгж хувиар өсгөх нөлөөг үзүүлээ. Түүнчлэн 2022 оны эхний 7 сард банкны системийн төгрөгийн эх үүсвэр 2.2 орчим их наяд төгрөгөөр буюу 10.8 хувиар буурсан бол гадаад валютын эх үүсвэр 1.5 их наяд төгрөгөөр буюу 23.6 хувиар өссөн байна. Үүнээс ханшийн нөлөөг хасч тооцвол банкны системийн гадаад валютын

¹³ Төсвийн алдагдал 788 тэрбум төгрөг, өрийн үндсэн төлбөрт 449 тэрбум төгрөг.

эх үүсвэр оны эхнээс 11.2 хувиар өссөн байна.

Зураг III.2.1.3

Банкуудын зээл, хадгаламжийн долларжилт




Эх сурвалж: Монголбанк

Улмаар банкны системийн эх үүсвэрийн долларжилт нэмэгдэх хандлага үргэлжлэн 2022 оны 7 дугаар сард 29.3 хувьд хүрсэн нь оны эхнээс 6 нэгж хувиар өссөн, ханшийн нөлөөг хасч тооцвол 26 хувьд хүрч, оны эхнээс 3.8 нэгж хувиар нэмэгджээ (Зураг III.2.1.3).

Зураг III.2.1.4

Арилжааны банкуудын зээлийн жилийн өсөлтийн бүрэлдэхүүн, салбаруудаар



Эх сурвалж: Монголбанк

Банкны системийн зээлийн өсөлт “10 их наядын цогц төлөвлөгөө”-ний нөлөөгөөр сүүлийн 5 улирлын турш эрчимжсэн хэдий ч 2022 оны 4 дүгээр сараас саарч эхэллээ. Тухайлбал, банкны системийн зээлийн үлдэгдэл¹⁴ 2022 оны 7 дугаар сард 23.1 их

¹⁴ Үнэт цаасжуулсан ипотекийн зээлийн нөлөөг хассан.


наяд төгрөгт хүрч өмнөх оны мөн үеэс 3.8 их наяд төгрөгөөр, жилийн **20.0** хувиар өссөн байна. Энэ нь 2022 оны 4 дүгээр сараас 9 нэгж хувиар буурсан дүн юм. Нийт зээлийн өсөлтийг эдийн засгийн салбаруудаар нь авч үзвэл худалдаа, үл хөдлөх, хэрэглээ болон хадгаламж барьцаалсан зээлүүд нь зээлийн өсөлтийг голлон бүрдүүлжээ (Зураг III.2.1.4).

Зээлийн зориулалтаар нь харвал бизнесийн зээлийн өсөлт 15 хувьд хүрсэн нь нийт зээлийн 9.2 нэгж хувь, хэрэглээ болон хадгаламж барьцаалсан зээлийн өсөлт 27.4 хувьд хүрсэн нь нийт зээлийн 6.7 нэгж хувь, ипотекийн зээлийн өсөлт 33.5 хувьд хүрсэн нь нийт зээлийн 4.1 нэгж хувийг тус тус бүрдүүлж байна.

Валютын төрлөөр нь авч үзвэл төгрөгийн зээлийн үлдэгдэл өмнөх оны мөн үеэс 24.1 хувиар нэмэгдэж, гадаад валютын зээлийн үлдэгдэл -21.1 хувиар буурав.

Зураг III.2.1.5

Банкны системийн нийт зээл олголт, эргэн төлөлт (Тухайн жилд өсөн нэмэгдэх)



Эх сурвалж: Монголбанк


Банкны системээс 2022 оны эхний 7 сард нийт 18.5 их наяд төгрөгийн зээл олгосон нь өмнөх оны мөн үеэс 2.5 их наяд төгрөгөөр буюу 15.7 хувиар өссөн байна. Харин зээлийн эргэн төлөлт эхний 7 сард 16.0 их наяд төгрөг байгаа нь өмнөх оны мөн үеэс

2.4 их наяд төгрөг буюу 17.7 хувиар өссөн дүн юм.

“Банкны зээлийн төлөв” түүвэр судалгаанаас харахад тайлант улиралд ихэнх банкууд зээлийн нөхцөл болон шалгуурыг үргэлжлүүлэн бага зэрэг чангаруулав. Зээлийн шалгуур нэмэгдэхэд эх үүсвэрийн зардал болон өрсөлдөөн нэмэгдсэн, барьцаа хөрөнгийн эрсдэл нэмэгдэж, банкны салбарын төлөв болон эдийн засгийн нөхцөл байдал муудсан нь гол нөлөөг үзүүлжээ. Түүнчлэн, зээлийн хэмжээ болон барьцаа хөрөнгийн үнэлгээг бууруулах, зээлийн хүүг нэмэгдүүлэх зэргээр зээлийн нөхцөлөө бага зэрэг чангаруулж эхлэв. Нийт банкуудын хувьд 2022 оны 2 дугаар улиралд ААН болон иргэдийн зээлийн эрэлт бага зэрэг өссөн гэж мэдээллэв. Банкууд 2022 оны 3 дугаар улиралд зээлийн нөхцөл болон шалгуураа үргэлжлүүлэн бага зэрэг чангаруулах төлөвтэй байна.¹⁵

Зураг III.2.1.6

Банкны системийн нийт зээлийн үлдэгдлийн бүтэц, эдийн засгийн салбаруудаар



Эх сурвалж: Монголбанк

“10 их наядын цогц төлөвлөгөө”-ний зээлүүд болон хэрэглээ болон хадгаламж барьцаалсан зээлийн өсөлт эрчимжсэн нөлөөгөөр зээлийн үлдэгдлийн бүтэц

¹⁵ “Банкны зээлийн төлөв” түүвэр судалгааны тайлан


өөрчлөгдөв. Тухайлбал, худалдаа, үл хөдлөх, хэрэглээ болон хадгаламж барьцаалсан зээлийн нийт зээлд хувь өмнөх жилийн 7 дугаар сараас 5.3 нэгж хувиар нэмэгджээ (Зураг III.2.1.6).

Банкны системийн анхаарал хандуулах зээлийн хэмжээ өмнөх жилийн мөн үеийн орчимд байгаа бол чанаргүй зээлийн үлдэгдэл бага зэрэг нэмэгдэв. Тухайлбал, чанаргүй зээлийн үлдэгдэл 2022 оны 7 дугаар сард жилийн 6.8 хувиар буюу 125 тэрбум төгрөгөөр нэмэгдэв. Үүнд, худалдааны салбарын чанаргүй зээл 31 хувиар, уул уурхайн салбарын чанаргүй зээл өмнөх жилийн мөн үеэс 28 хувиар өссөн нь голлон нөлөөлж байна. Анхаарал хандуулах зээлийн хувьд 2022 оны 7 дугаар сард жилийн 1.5 хувиар буюу төдийлөн өөрчлөлтгүй байв.

Зээлийн өсөлт эрчимжиж нийт зээлийн үлдэгдэл огцом нэмэгдсэн нь анхаарал хандуулах болон чанаргүй зээлийн нийт зээлд эзлэх хувь буурахад голлон нөлөөлөв. Тодруулбал, чанаргүй болон анхаарал хандуулах зээл нь нийт зээлийн харгалзан 9.1 хувь болон 5.3 хувийг бүрдүүлж байна. Эдгээр нь өмнөх жилийн мөн үеэс тус тус 1.1 нэгж хувь болон 1.0 нэгж хувиар буурсан дүн юм (Зураг III.2.1.7).

Зураг III.2.1.7

Банкуудын чанаргүй зээлийн жилийн өсөлт, эдийн засгийн салбаруудаар




Эх сурвалж: Монголбанк

III.2.2 Хүү

Монголбанкны Мөнгөний бодлогын хорооны 2022 оны 6 дугаар сарын ээлжит хурлаар бодлогын хүүг 1 нэгж хувиар өсгөж 10 хувьд хүргэх, 9 дүгээр сарын ээлжит хурлаар 2 нэгж хувиар нэмэгдүүлж 12 хувьд хүргэх шийдвэр гаргалаа. Тайлант хугацаанд банк хоорондын захын хүүнүүд хүүний коридорын голч буюу бодлогын хүүний орчимд тогтвортой байна. Хөнгөлөлттэй хүүтэй зээлүүдийн нөлөөг хасч тооцсон банкны системийн төгрөгийн зээлийн хүү сүүлийн саруудад 14-15 хувийн орчимд байв.

Зураг III.2.2.1

БХЗ-ын хэлцлийн хүү



Эх сурвалж: Монголбанк


Банк хоорондын захын жигнэсэн дундаж хүү 2022 оны 7 дугаар сард өмнөх сараас 0.61 нэгж хувиар өсч 10.12 хувьд хүрэв. Үүнд овернайт зээлийн хүү 0.55 нэгж хувиар өсч 10 хувьд, ТБҮЦ барьцаалсан репо хэлцлийн хүү 0.4 нэгж хувиар өсч 10 хувьд, банк хоорондын хадгаламжийн хүү 0.71 нэгж хувиар өсч 10.35 хувьд, ТБҮЦ-ны шууд хэлцлийн хүү 0.64 нэгж хувиар өсч 10 хувьд хүрсэн байна. (Зураг III.2.2.1).

Энэ оны 7 дугаар сард банкуудын шинээр татсан төгрөгийн хадгаламжийн хүү өмнөх оны мөн үеэс 1.57 нэгж хувиар өсч 8.27 хувьд хүрсэн бол шинээр олгосон төгрөгийн зээлийн дундаж хүү (хөнгөлөлттэй хүүтэй зээлүүдийг хасч тооцвол) 0.31 нэгж хувиар буурч 14.27 хувьд хүрлээ. Харин хөнгөлөлттэй хүүтэй зээлийг оруулж тооцвол нийт зээлийн хүү 1.22 нэгж хувиар өссөн буюу 14 хувьтай байна. Улмаар зээл,

хадгаламжийн хүүний зөрүү өмнөх оны мөн үеэс 0.35 нэгж хувиар буурч 5.71 хувьд хүрэв (Зураг III.2.2.2).

Зураг III.2.2.2

Шинээр олгосон зээлийн болон шинээр татсан хадгаламжийн хүү



Эх сурвалж: Монголбанк

Шинээр олгосон гадаад валютын зээлийн хүү болон шинээр татсан гадаад валютын хадгаламжийн хүүний зөрүү нэмэгдлээ. Шинээр олгосон гадаад валютын зээлийн дундаж хүү 2022 оны 7 дугаар сард өмнөх оны мөн үеэс 0.27 нэгж хувиар өсч 9.9 хувьд хүрсэн бол шинээр татсан гадаад валютын хадгаламжийн хүү өмнөх оны мөн үеэс 0.5 нэгж хувиар буурч 2.78 хувьд хүрснээр гадаад валютын зээл, хадгаламжийн хүүний зөрүү өмнөх оны мөн үеэс 0.76 нэгж хувиар өсч 7.13 хувьд хүрэв (Зураг III.2.2.2).

Хүснэгт III.2.2.1

Шинээр олгосон зээлийн хүү (₮), зээлдэгчдээр

Хувь, %	2021.07 сар	2022.07 сар
Зээлийн хүү (хөнгөлөлттэй зээлийг оруулснаар)	12.8	14.0
Зээлийн хүү	14.6	14.3
i. Улсын байгууллага	9.7	3.3
ii. Хувийн байгууллага	14.9	14.1
Үүнд: ААН-ийн ЖДҮ	9.8	14.0
iii. Санхүүгийн байгууллага	16.5	17.7
iv. Иргэд	14.8	14.7
Үүнд: Иргэдийн ЖДҮ	12.7	15.0
Хэрэглээ, хад. барь	14.6	14.9
v. Бусад байгууллага	7.2	18.7

Эх сурвалж: Монголбанк


II.2.3 Валютын ханш

Төгрөгийн ам.доллартай харьцах ханш сүүлийн саруудад алгуур суларч, 2022 оны 8 дугаар сарын эцсийн байдлаар 3200.2 төгрөгтэй тэнцэж байна. Энэ нь оны эхнээс 12.3 хувиар суларсан үзүүлэлт юм /Зураг III.2.3.1/.

Төгрөгийн ханш ам.долларын эсрэг ийнхүү сулрахад нэг талаас, АНУ-ын Холбооны Нөөцийн банк бодлогын хүүгээ хүлээлтээс хурдан өсгөж, ам.долларын ханш бусад валютуудын эсрэг чангарсан нь нөлөөлөв. Нөгөө талаас, экспортын орох урсгалууд саарч, импорт нэмэгдсэнээр гадаад валютын урсгал цэвэр дүнгээр 2022 оны 1-8 дугаар сарын хооронд 4 дүгээр сараас бусад үед алдагдалтай байгаа нь ханш сулрах дарамтыг нэмэгдүүллээ.

Зураг III.2.3.1

Төгрөгийн ам.доллартай харьцах ханш




Эх сурвалж: Монголбанк

Сүүлийн саруудад ханшийн сулрах хурд нэмэгдэж, гадаад худалдааны эргэлтээр жигнэж тооцсон төгрөгийн нэрлэсэн ханш (NEER) энэ оны 7 дугаар сард өмнөх оны мөн үеэс 7.3 хувиар суларсан байна. Үүнээс төгрөгийн ханш рублийн эсрэг хамгийн хурдтай буюу өмнөх оны мөн үеэс 32.9 хувиар суларсан бол еврогийн эсрэг 4.3 хувиар чангараад байна. Европын орнуудад эрчим хүчний хямрал нүүрлэсэн, эдийн засгийн өсөлт удааширсан, аж үйлдвэрлэл саарсан, гадаад, дотоод хүүний зөрүү

нэмэгдсэн зэргээс шалтгаалан еврогийн ханш ам.долларын эсрэг хурдтай суларснаар төгрөгийн ханш ийнхүү еврогийн эсрэг чангарлаа /Зураг III.2.3.2/.

Зураг III.2.3.2

Төгрөгийн гол валютуудтай харьцах ханш, нэрлэсэн ханшийн (NEER) жилийн өөрчлөлт



Эх сурвалж: Монголбанк

Төгрөгийн нэрлэсэн ханш 7.3 хувиар суларсан ч гадаад үнэтэй харьцуулахад дотоод үнэ 7.8 хувиар нэмэгдсэнээр бодит ханш энэ оны 7 дугаар сард өмнөх оны мөн үеэс 0.5 хувиар чанга тогтлоо. Энэ нь сүүлийн 4 улирал дараалан чангарсан үзүүлэлт болж байна /Зураг III.2.3.3/.

Зураг III.2.3.3

Төгрөгийн бодит ханшийн жилийн өөрчлөлт




Эх сурвалж: Монголбанк

Төгрөгийн ханш ам.долларын эсрэг суларсантай холбоотойгоор төгрөгийн харьцангуй өгөөж сүүлийн хагас жилийн

хугацаанд сөрөг түвшинд хадгалагдаж, 2022 оны 7 дугаар сард -0.7 хувьтай байна /Зураг III.2.3.4/. Төгрөгийн харьцангуй өгөөж ийнхүү хасах түвшинд байгаа нь төгрөгийн хадгаламж буурч, валютын хадгаламж өсөх нэг шалтгаан болж байна. Тодруулбал, 2022 оны 7 дугаар сарын байдлаар төгрөгийн хадгаламж өмнөх оны мөн үеэс 12.5 хувиар буурсан бол валютын хадгаламж 10.2 хувиар өссөн дүнтэй байна.

Зураг III.2.3.4

Төгрөгийн харьцангуй өгөөж



Эх сурвалж: Монголбанк

III.2.4 Хөрөнгийн зах зээл


Тайлант улиралд орон сууцны үнэ өмнөх улирлаас бага зэрэг буурч, хөрөнгийн захын идэвхжил үргэлжлэн суларлаа.

Орон сууцны зах зээл

“Тэнхлэг зууч” ХХК-ий мэдээллээр орон сууцны үнийн өсөлт саарч, орон сууцны үнэ өмнөх улирлаас бага зэрэг буурлаа. Тодруулбал, 2021 оны сүүлийн улиралд 14.8 хувь хүртэл өсч байсан орон сууцны үнэ тайлант улиралд өмнөх оны мөн үеэс 4.6 хувиар өсөв. Түүнчлэн, орон сууцны үнэ өмнөх улирлаас 0.1 хувиар буурсан бөгөөд шинэ болон хуучин орон сууцны үнэ аль аль нь 0.4 орчим хувиар өмнөх улирлаас буурсан дүнтэй байна.

Зураг III.2.4.1

Орон сууцны үнэ ба түрээсийн үнийн өсөлт




Эх сурвалж: YCX, Тэнхлэг-Зууч

Орон сууцны үнийн өсөлт ийнхүү саарах хандлага ажиглагдаж байгаа ч түрээсийн үнэ өсөлттэй хэвээр байна. Тухайлбал, түрээсийн үнэ энэ оны 2 дугаар улиралд өмнөх оны мөн үеэс 11.0 хувиар, өмнөх улирлаас 1.1 хувиар тус тус өслөө (Зураг III.2.4.1).

Өнгөрсөн онд “Эрүүл мэндээ хамгаалж, эдийн засгаа сэргээх 10 их наядын цогц төлөвлөгөө”-ний хүрээнд ипотекийн зээлийн санхүүжилт нэмэгдэн, орон сууцны эрэлт эрчимжихэд нөлөөлж байв. Харин энэ онд санхүүжилтийн хэмжээ буурч, тайлант улиралд шинээр ипотекийн зээл авсан зээлдэгчдийн тоо өмнөх оны мөн үетэй харьцуулахад 33.6 хувиар буурчээ¹⁶. Энэ нь орон сууцны эрэлт буурах, улмаар орон сууцны үнийн өсөлт саарахад нөлөөлж байна.

Зураг III.2.4.2

Орон сууцны барилгын өртгийн индекс



Эх сурвалж: YCX

Тайлант улиралд барилгын өртгийн индекс өмнөх оны мөн үеэс 23.1 хувиар, өмнөх улирлаас 8.3 хувиар тус тус өсч¹⁷, барилгын өртөг нэмэгдэх хандлага хэвээр байгаа нь цаашид орон сууцны үнийг нэмэгдүүлэх эрсдэлтэй байна (Зураг III.2.4.2). Хилийн хязгаарлалт, нийлүүлэлтийн саатал үргэлжилж, тээврийн зардал өсөж байгаа нь импортын барилгын материалын өртөг нэмэгдэхэд нөлөөлж байна. Түүнчлэн, машин механизмын түрээсийн зардал, цалингийн зардал өссөнөөр барилгын өртөг ийнхүү өсөлттэй хэвээр байна.

Хүснэгт III.2.4.1

Орон сууцны захын үзүүлэлтүүд

		2022-Q1	2022-Q2
Орон сууцны үнийн өсөлт, %			
Тэнхлэг Зууч	улирлаар	-4.8	-0.3
	жилээр	7.8	4.6
Түрээсийн үнийн өсөлт, %	улирлаар	-0.4	1.1
	жилээр	11.2	11.0


Эх сурвалж: YCX, Тэнхлэг-Зууч

¹⁶ Эх сурвалж: Монголбанк. Банкны өөрийн эх үүсвэрийн болон ОСИСТТБХ-ийн эх үүсвэрийн зээл.

¹⁷ Эх сурвалж: YCX

Зураг III.2.4.3

Үнэ-орлого ба үнэ-түрээсийн харьцаа



Эх сурвалж: УСХ, Монголбанк


“Тэнхлэг зууч” ХХК-ий орон сууцны үнийн индексийг ашиглан орон сууцны захын төлөвийг илтгэх харьцаа үзүүлэлтүүдийг тооцвол, түрээсийн үнэ өмнөх улирлаас 1.1 хувиар өсөж, орон сууцны үнэ өмнөх улирлаас буурснаар үнэ-түрээсийн харьцаа бага зэрэг буурав. Үнэ, түрээсийн харьцаа ийнхүү буурч байгаа нь орон сууцны үнэ хэт өсөж хөөсрөх эрсдэл буурч байгааг илтгэж байна. Тайлант улиралд өрхийн дундаж орлого өмнөх улирлын орчимд байж, орон сууцны үнэ бага зэрэг буурсан нөлөөгөөр үнэ-орлогын харьцаа ялимгүй буурсан нь орон сууц худалдан авах чадвар алгуур сэргэх хандлагатай байгааг илтгэнэ.

Хөрөнгийн зах зээл

Хөрөнгийн захын идэвхжил тайлант улиралд сулран, ТОП-20 индекс болон зах зээлийн үнэлгээ буурах хандлага үргэлжлэв. Тодруулбал, хөрөнгийн захад бүртгэлтэй “АПУ”, “Ард санхүүгийн нэгдэл”, “Таван толгой”, “Говь” зэрэг ТОП-20 индексийг бүрдүүлэгч дийлэнх компаниудын хувьцааны үнэ оны эхнээс буураад байна. Улмаар өнгөрсөн оны турш эрчимтэй өссөн ТОП-20 индекс энэ оны эхнээс тасралтгүй буурч, 7 дугаар сарын дунджаар 33,587.5 нэгжид хүрсэн нь оны эхнээс 20.9 хувиар суларсан үзүүлэлт боллоо (Зураг III.2.4.4).

Зураг III.2.4.4

Хөрөнгийн захын голлох үзүүлэлтүүд



Эх сурвалж: Монголын хөрөнгийн бирж

Зах зээлийн үнэлгээ энэ оны эхний хагаст тасралтгүй буурч, 6 дугаар сард өмнөх оны мөн үеэс 16.7 хувиар саарч, 4.8 их наяд төгрөгт хүрэв. Харин 7 дугаар сард зах зээлийн үнэлгээ 5.0 их наяд төгрөгт хүрч, өмнөх сараас бага зэрэг өслөө (Зураг III.2.4.4).

Энэ оны эхний 7 сарын байдлаар нийт 300.7 тэрбум төгрөгийн үнэт цаасны арилжаа хийгдэв. Үүнээс, 76.6 тэрбум төгрөгийг “Эрдэнэс Таван Толгой” компаниас тайлант улиралд гаргасан бондын анхдагч зах дээрх арилжаа болон 6 дугаар сард “Симпл ассет ТЗК” компаний гаргасан 50 тэрбум төгрөгийн үнийн дүн бүхий хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны анхдагч зах зээл дээрх арилжаа тус тус бүрдүүллээ. Улмаар сүүлийн саруудын үнэт цаасны арилжааны дүнд компанийн бонд болон хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны анхдагч захын арилжаа томоохон дүн эзлээд байна. Эхний 7 сард хийгдсэн нийт арилжааны 34.3 хувийг компанийн бонд, 19.7 хувийг хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас, 45.2 хувийг хувьцааны арилжаа эзэлж байна¹⁸.

¹⁸ Эх сурвалж: Монголын хөрөнгийн бирж

Зураг III.2.4.5

Хөрвөх чадварын харьцаа



Харин 2022 оны 7 дугаар сарын байдлаар “АПУ”, “Ард санхүүгийн нэгдэл”, “Сентрал экспресс си ви эс” компаниуд үнийн дүнгээр хувьцааны арилжааны идэвхийг тэргүүлсэн бол тоо ширхгээр “АПУ”, “Монос хүнс”, “Сентрал экспресс си ви эс” компаниудын хувьцааны арилжаа тэргүүлсэн байна. Хөрөнгийн захын хөрвөх чадварын харьцаа¹⁹ хувьцааны арилжааны хувьд тооцоолоход 2022 оны 7 дугаар сард 2.7 хувьд хүрэн, оны эхнээс 6.6 нэгж хувиар буурч, хөрөнгийн зах дээрх хувьцааны арилжааны идэвжил тайлант улиралд сулраад байна.

III.3 Нэгдсэн төсөв болон Засгийн газрын өр

Нэгдсэн төсөв: Оны эхний 7 сарын байдлаар төсвийн тэнцвэржүүлсэн орлого өмнөх оны мөн үеэс 13.7 хувиар нэмэгдэж 8.7 их наяд төгрөгт, төсвийн зардал 11.9 хувиар өсөж 9.5 их наяд төгрөгт хүрч, төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл 788 тэрбум төгрөгийн алдагдалтай гарлаа (Хүснэгт III.3.1).

Хүснэгт III.3.1

Төсвийн үндсэн үзүүлэлтүүд

Их наяд төгрөг	2021	2022	2022.07	
	Гүй.	Тод.2	Гүй.	Гүй. хувь
Нийт орлого	14.3	16.3	9.4	98.1
Сангийн орлого	1.6	0.8	0.7	191
Тэнцвэржүүлсэн орлого	12.7	15.5	8.7	94.3
Татварын орлого	11.3	13.6	8.2	97.9
Татварын бус орлого	1.4	1.9	0.5	59.1
Нийт зардал	15.6	17.9	9.5	82.4
Анхдагч зардал	14.8	17.0	9.0	82.4
Хүүний зардал	0.8	0.9	0.5	81.9
Нийт тэнцэл	-1.3	-1.6	-0.1	
ДНБ-д эзлэх хувь	-3.0%	-3.5%	-0.1%	
Тэнцвэржүүлсэн тэнцэл	-2.9	-2.4	-0.8	
ДНБ-д эзлэх хувь	-6.6%	-5.1%	-1.7%	
Анхдагч тэнцэл	-2.1	-1.5	-0.3	
ДНБ-д эзлэх хувь	-4.7%	-3.2%	-0.7%	


Эх сурвалж: Сангийн яам

Тэнцвэржүүлсэн орлого 2022 онд:

Өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр, нэмэгдсэн өртгийн албан татвар, нийгмийн даатгалын шимтгэл, хувь хүний орлогын албан татварын орлого өссөн бол аж ахуй нэгжийн орлогын албан татварын орлого, татварын бус орлого буураад байна (Зураг III.3.1).

Зураг III.3.1

Төсвийн орлогын бүтэц



Эх сурвалж: Сангийн яам

Төсвийн орлого ийнхүү нэмэгдэхэд:

¹⁹ Хөрвөх чадварын харьцаа = $\frac{\text{Хувьцааны нийт арилжаа}}{\text{Зах зээлийн үнэлгээ}}$;

- 2022 оноос эхлэн Ирээдүйн өв сан (ИӨС)-гийн орлогыг тэнцвэржүүлсэн орлогод бүртгэхээр шийдвэрлэсэн,
- Нийгмийн даатгалын шимтгэлийн хөнгөлөлт зогссон,
- Эдийн засгийн нэрлэсэн өсөлт үнийн өсөлтөөс шалтгаалан өндөр байсан нь төсвийн орлогын суурийг тэлсэн зэрэг хүчин зүйлс нөлөөлөв.

Нөгөө талаас өнгөрсөн оны эхээр төсвийн орлогод бүртгэгдсэн “Оюу Толгой” компанийн 1.0 их наяд төгрөгийн орлогын суурь нөлөө, энд онд газрын тос, навигацийн орлого тасарсан зэрэг нь төсвийн орлогын өсөлтийг сааруулж байна.

Сүүлийн жилүүдийн дунджаар татварын бус орлогын 20 орчим хувийг газрын тосны орлого бүрдүүлдэг бөгөөд оны эхнээс боловсруулаагүй нефтийн экспорт зогсонги байдалд ороод байна.


Нийт зардал, цэвэр зээл 2022 онд: Төсвийн зардлын дийлэнх хэсгийг татаас, шилжүүлгийн зардал эзэлсэн хэвээр байгаа бол хөрөнгийн зардал зарцуулалт сүүлийн 2 сард идэвхжилээ (Зураг III.3.2).

“Хуримтлалтай хүүхэд”, Ковид-19 тусламж үйлчилгээ, тэтгэврийн доод хэмжээг нэмэгдүүлэх зэрэг арга хэмжээний үр дүнд төсвийн татаас, шилжүүлгийн зардал цар тахлын өмнөх буюу 2019 оны мөн үетэй харьцуулахад 3 дахин нэмэгдэж, төсвийн зардлын 60 гаран хувийг дангаар эзэлж байна.

Оны эхний 7 сарын байдлаар 1.4 их наяд төгрөгийг төсвийн хөрөнгө оруулалтад зарцуулсан нь өнгөрсөн оны мөн үеэс 45 хувиар өндөр дүн юм. Үүний 600 тэрбум төгрөг нь сүүлийн 2 сард зарцуулагдлаа.

Зураг III.3.2

Төсвийн зардлын бүтэц



Эх сурвалж: Сангийн яам

Өнөөгийн үнэ цэнээр илэрхийлсэн Засгийн газрын нийт өр: Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд зааснаар 2022 оны өрийн хязгаар буюу өнөөгийн үнэ цэнээр илэрхийлсэн засгийн газрын нийт өр/тухайн оны үнээр илэрхийлсэн ДНБ-ий харьцаа 70 хувь бөгөөд 4-р сарын 29-нд батлагдсан 2 дахь тодотголоор энэ онд 60.7 хувьтай байхаар төлөвлөжээ (Хүснэгт III.3.2).

Хүснэгт III.3.2

Өнөөгийн үнэ цэнээр илэрхийлсэн Засгийн газрын өр болон зээлийн үйлчилгээний төлбөр

Төрөл	2020	2021	2022*
	Гүй.	Гүй.	Тод.
Засгийн газрын нийт өр (ӨҮЦ)	23024	22056	28262
<i>ДНБ-д эзлэх хувь</i>	62.3	51.3	60.7
Өрийн хязгаар	70.0	70.0	70.0
Зээлийн үйлчилгээний төлбөр	959	828	909
<i>Төсвийн орлогод эзлэх хувь</i>	10.2	6.5	5.8
Төсвийн тэнцэл	-4539	-2909	-2387
<i>ДНБ-д эзлэх хувь</i>	-12.2	-6.6	-5.1

Эх сурвалж: Сангийн яам, Монголбанк


IV. ЭДИЙН ЗАСГИЙН ГАДААД ОРЧИН

IV.1 Эдийн засгийн гадаад орчны төсөөлөл

Гадаад эрэлт: Гадаад орчны төлөв төсөөлөл шинэчлэгдэх бүрт муудаж, цаашид ч энэ байдал үргэлжлэх хандлагатай болсныг олон улсын байгууллагууд онцоллоо. Тухайлбал, 2022 оны глобал эдийн засгийн өсөлтийн төсөөлөл оны эхэнд 5 хувь, 5-р сард 3.3 хувь байсан бол 8-р сард 3.0 хувь болж буурчээ. Дунд хугацаанд улс орнууд цар тахлын нөхцөлд дасан зохицож, төсөв, мөнгөний бодлогууд нормалчлагдан, эдийн засгийн өсөлт урт хугацааны хэвийн түвшиндээ тогтворжих хүлээлт хэвээр байна.

Зураг IV.1.1

Гадаад эрэлт өмнөх төсөөллөөс муудлаа.



Эх сурвалж: ОУВС, Блумберг, Рубини, EIU

Гадаад эрэлтийг БНХАУ 90%, Евро бүс 8%, ОХУ 2% гэж тооцов.

Манай гадаад эрэлтийг тодорхойлогч голлох улсуудаар дэлгэрүүлж тайлбарлавал:

БНХАУ-ын “Тэг-КОВИД” бодлогын хүрээнд томоохон хотуудад хатуу хөл хорио тогтоосон нь тус улсын хэрэглээ, аж үйлдвэрлэл, тээвэр, логистик, экспортод сөргөөр нөлөөлж өсөлтийн төсөөлөл нь муудахад голлон нөлөөлөв. Түүнчлэн, БНХАУ-ын үл хөдлөх хөрөнгийн салбарын уналт үргэлжилсээр байна.

ОХУ-ын хувьд улс орнуудын хэрэгжүүлсэн хориг арга хэмжээний улмаас шалтгаалан тус улсын эдийн засаг уналттай байгаа ч

өмнөх төсөөлөлтэй харьцуулахад сайжирчээ. Үүнд ОХУ-аас БНХАУ болон Энэтхэг улсуудад эрчим хүчний түүхий эдийн нийлүүлэлтээ нэмэгдүүлсэн нь эергээр нөлөөлсөн байна.

Гадаад инфляц: Дэлхий нийтэд үнийн өсөлт эрчимжсээр байна. Олон улсад инфляц сүүлийн жилүүдэд байгаагүй дээд түвшиндээ хүрсэн учраас Европын Холбоо, АНУ, Англи зэрэг томоохон эдийн засагтай орнууд өсөж буй инфляцыг тогтоон барих улмаар бууруулах зорилтыг тавин мөнгөний бодлогын хүүгээ эрчтэй нэмэгдүүлэх арга хэмжээг авч байна. Гэвч эрчим хүчний хямрал үргэлжилж, Европ болон БНХАУ-д ган болсны улмаас усан цахилгаан станциуд доголдолд орсон нь нөхцөл байдлыг дордуулав. Цаашлаад Европын Холбооны орнуудын хувьд эрчим хүчний үнэ дахин өсөж болзошгүй байгаа нь зардлын шалтгаантай үнэ өсөх дарамтыг нэмэгдүүлж байна.

Олон улсын байгууллагуудын төсөөллөөр глобал инфляц 2024 оноос тогтворжих хүлээлттэй.

Гадаад хүү: БНХАУ эрэлтийг дэмжих зорилгоор энэ оны 8-р сард мөнгөний бодлогын хүүгээ 0.1 хувиар бууруулжээ. Харин АНУ-ын 8-р сарын инфляцын түвшин 8.3 хувьд хүрч төсөөллөөс өндөр гарсан тул Холбооны Нөөцийн Сан бодлогын хүүг дахин 0.75 хувиар өсгөж 3-3.25 болгосноор сүүлийн 14 жилийн хугацаанд хамгийн өндөр түвшинд хүргэв. Мөн инфляцыг бууруулах зорилгоор бодлогын хүүг Европын холбоо 0.75 нэгж хувь, Англи 0.5 нэгж хувиар тус тус нэмжээ. Улс орнуудын хувьд цаашид ч бодлогын хүүгээ нэмэх хандлага ажиглагдаж байна.


Худалдааны нөхцөл:

Экспортын үнэ өмнөх оноос буурч, худалдааны нөхцөл 2022 онд муудах хүлээлт хэвээр байна (Зураг IV.1.2).

Дэлхийн зах зээл дээрх газрын тос, хүнсний үнэ өсөхийн зэрэгцээ улс орнуудын инфляц хурдтай өсөж байгаа нь импортын үнэ өмнөхөөс нэмэгдэхэд нөлөөллөө. Харин олон улсын зах зээл дээрх голлох түүхий эдийн эрэлт богино хугацаанд өндөр түвшинд хадгалагдах ч дунд хугацаанд нийлүүлэлт тогтворжсоноор экспортын үнэ алгуур буурах хүлээлттэй байна.

Зураг IV.1.2

Худалдааны нөхцөл, экспорт, импортын үнийн өөрчлөлт



Эх сурвалж: Монголбанкны тооцоолол

IV.2 Түүхий эдийн үнэ

Түүхий эдийн үнийн төлөв дэлхийн эдийн засгийн төлөв байдал, төв банкуудын бодлого, БНХАУ-ын цар тахлын эсрэг баримтлах арга хэмжээ, ОХУ-Украины геополитикийн нөхцөл байдлаас хүчтэй хамаарахаар байна.

Зэс: Зэсийн үнэ 8-р сард 7953 ам.доллар хүрч өмнөх сараас 5.4 хувиар өссөн. Ийнхүү үнэ өсөхөд зэс нийлүүлэлтээрээ тэргүүлэгч Чили улс үйлдвэрлэлээ 4.3 хувиар бууруулж нийлүүлэлтийг багасгасан нь нөлөөлөв. Зэсийн үнэ дундажаар 2022 онд 8685 ам.доллар/тонн, 2023 онд 8200 ам.доллар/тоннд хүрч өмнөх төсөөллөөс буурлаа.

Алт: Алтны үнэ 8-р сарын байдлаар 1711 ам.доллар/унц болж өмнөх сарын үнээс 3.1 хувиар буурав. Хөгжингүй орнуудын зорилгоос давсан инфляцын түвшин,

геополитикийн хямралаас үүдэлтэй зах зээл дээрх тодорхой бус байдал алтны үнийг өндөр түвшинд хадгалагдах хөшүүрэг болж байгаа ч нөгөө талаас АНУ-ын Холбооны Нөөцийн Сангийн инфляцын эсрэг авч хэрэгжүүлж буй арга хэмжээний нөлөөгөөр нэрлэсэн хүүгийн түвшин өсөж, ам.долларын ханшийг нэмэгдүүлэн алтны үнийг бууруулах чиглэлд нөлөөлжээ. Олон улсын судалгааны байгууллагуудын мэдээллээр алтны үнэ 2022 онд дунджаар 1825.74 ам.доллар/унц, 2023 онд 1843.75 ам.доллар/унц-д хүрэх төсөөлөлтэй байна.

Коксжих нүүрс: Австралийн зах зээл дээр коксжих нүүрсний үнэ 8-р сарын байдлаар 285 ам.доллар/тн болж өмнөх сараас 85 ам.доллараар нэмэгджээ. Үүнд Индонезийн нүүрс олборлолтын 48 компани дотоодын хэрэгцээгээ хангах зорилгоор нүүрсний экспортоо зогсоосон нь том нөлөөтэй байв. Харин БНХАУ-ын импортолж буй нүүрсний үнэ 8-р сард тонн тутамдаа 280 ам.доллар болж өмнөх сараас 35 ам.доллараар буурсан нь ОХУ хөнгөлөлттэй үнээр нүүрс их хэмжээгээр нийлүүлж байгаа нь нөлөөлжээ.

Төмрийн хүдэр: Нэг тонн төмрийн хүдрийн үнэ 8-р сарын байдлаар 95 ам.доллар болж өмнөх сараас 8.7 хувиар буурлаа. Энэ нь БНХАУ-ын Тэг-Ковид бодлого болон тус улсын үл хөдлөх хөрөнгийн салбарын хямралаас үүдэн эрэлт буурсантай холбоотой байна. Тухайлбал, Шиньзен, Далиан хотуудад зэрэг томоохон аж үйлдвэрийн хотуудад тогтоосон хөл хорио төмрийн хүдрийн эрэлтэд сөргөөр нөлөөлсөн байна. Олон улсын судалгааны байгууллагуудын төсөөллийн дунджаар төмрийн хүдрийн үнэ 2022 онд 125 ам.доллар/тонн, 2023 онд 105 ам.доллар/тонн болж алгуур буурах тооцоолол боловсруулсан байна

Газрын тос: Нэг баррель Brent маркын газрын тосны үнэ 2022 оны 8-р сарын дунджаар 97 ам.доллар буюу өндөр


түвшинд хэвээр байв. Энэ нь ОХУ-Украины нөхцөл байдал болон ОПЕК-ийн орнууд энэ жил газрын тос үйлдвэрлэлд бага зардал төлөвлөсөн зэргээс шалтгаалж нийлүүлэлтээ хязгаарласантай холбоотой байна. Мөн “Их-7” орнууд ОХУ-ын газрын тосны үнэд хязгаар тогтоох нь зүйтэй гэж үзсэн бөгөөд энэ нь ОХУ-ын дайн санхүүжүүлэх орлогыг хумина гэж тайлбарлав. Гэвч тус хоригоос үл шалтгаалан БНХАУ, Энэтхэг зэрэг томоохон орнуудад ОХУ хөнгөлөлттэй үнээр газрын тос их хэмжээгээр нийлүүлсээр байна. Блүмбергийн шинжээчдийн төсөөллийн дунджаар 2022 онд 102 ам.доллар/баррель, 2023 онд 96.25 ам.доллар/баррель болж өмнөх төсөөллөөс буурлаа.

IV.3 Төлбөрийн тэнцэл

Урсгал тэнцлийн алдагдал өндөр байснаас шалтгаалж **Монгол улсын төлбөрийн тэнцэл 2022 оны II улиралд 104.4 сая ам.долларын алдагдалтай гарлаа**²⁰. Тодруулбал, 2022 оны II улиралд экспорт өмнөх оны мөн үеэс 400 орчим сая ам.доллароор нэмэгдсэн ч импортын төлбөр илүү хурдтай өсөж, тээврийн үйлчилгээний зардал тэлсэн тул урсгал тэнцлийн алдагдал өмнөх оны мөн үеэс 115 сая ам.доллароор өндөр байв (Зураг IV.3.1). Харин санхүүгийн дансны ашиг урсгал тэнцлийн том алдагдлыг санхүүжүүлэхэд хангалтгүй байлаа. Улмаар гадаад валютын улсын нөөц оны эхнээс 1.3 тэрбум ам.доллараар буурч, 2022 оны 6-р сарын эцэст 3097.3 сая ам.долларт хүрсэн нь сүүлийн 3 сарын дунджаар тооцсон валютын төлбөртэй барааны импортын 4.2 сарын хэрэгцээг хангах түвшин юм.

Зураг IV.3.1

2022 оны эхний хагаст төлбөрийн тэнцлийн алдагдал 1.1 тэрбум ам.долларт хүрэв.



Төлбөрийн тэнцлийг гол бүрэлдэхүүн хэсгүүдээр дэлгэрүүлж тайлбарлавал:

Экспортын орлого тайлант улиралд өмнөх оны мөн үеэс 62.4 хувиар нэмэгдэхэд чулуун нүүрс, зэсийн хүдэр, баяжмал, цайрын хүдэр, баяжмал, мөнгөжөөгүй алтны экспорт мөнгөн дүнгээр өссөн нь нөлөөлөв. Харин төмрийн хүдэр, баяжмал, боловсруулаагүй нефть, мөнгөний хүдэр, баяжмалын экспортын орлого буурчээ.

БНХАУ-д “Тэг-КОВИД” бодлого хэрэгжиж байгаа ч манай улсын уул уурхайн экспортын гол боомт болох Гашуунсухайт боомт тасралтгүй ажиллаж, хилээр нэвтрэх нүүрс тээврийн автомашины тоо алгуур нэмэгдэж байна. Түүнчлэн, 7 сар гаруй хугацаанд хаалттай байсан Шивээхүрэн боомт 6-р сарын эхээр үйл ажиллагаагаа дахин сэргээв. Энэхүү эерэг нөлөөгөөр нүүрс, зэсийн баяжмалын тээвэр II улиралд харьцангуй сайн үргэлжилж биет хэмжээ өмнөх оны мөн үеэс харгалзан 2.1 болон 1.4 дахин өслөө. Харин төмрийн хүдрийн үнэ болон экспортын хэмжээ өмнөх оны мөн үеэс буурсан хэвээр байна. Боловсруулаагүй нефтийн хувьд тээвэр II улиралд үргэлжилж эхэлсэн боловч удаашралтай байна (Хүснэгт IV.3.1).

²⁰ Төлбөрийн тэнцлийн дэлгэрэнгүй статистикийг stat.mongolbank.mn хаягт хандан авах боломжтой.

Хүснэгт IV.3.1

Зэс, нүүрсний экспорт нийт экспортын өсөлтийг голлон бүрдүүлж байна.

	2021 II	2022 II	Жилийн өсөлт %	Өсөлтөд эзлэх %
Нийт экспорт	2,086	3,388	62.4	62.4
Чулуун нүүрс	328	1,674	409.9	64.5
Зэсийн хүдэр, баяжмал	692	880	27.2	9.0
Цайрын хүдэр, баяжмал	55	114	108.5	2.8
Мөнгөжөөгүй алт	192	226	17.5	1.6
Молибдений хүдэр, баяжмал	16	25	56.9	0.4
Ноолуур	178	179	0.4	0.0
Жонш, лейцит, нефелинт	42	35	-16.1	-0.3
Мах, махан бүтээгдэхүүн	15	2	-88.4	-0.7
Мөнгө	51	23	-54.9	-1.3
Боловсруулаагүй нефть	90	12	-86.3	-3.7
Төмрийн хүдэр, баяжмал	312	116	-62.7	-9.4
Бусад	114	100	-11.8	-0.6

Эх сурвалж: ГЕГ

Импорт 2022 оны II улиралд 29.9 хувиар өсөхөд импортын бүх бүлгүүд, тэр дундаа нефть, хэрэглээний бүтээгдэхүүний импорт хамгийн өндөр нөлөөлөв (Хүснэгт IV.3.2).

Нефтийн бүтээгдэхүүний импортын өсөлт нь газрын тосны үнээс голлон шалтгаалж байгаа бол хэрэглээний бүтээгдэхүүний импортын өсөлт нь биет хэмжээний²¹ өсөлтөөр түлхүү тайлбарлагдаж байна. Тодруулбал, тайлант улиралд өрхийн хэрэглээний өсөлт өндөр байж, өмнөх оны мөн үеэс 5.1 хувиар өссөн нь ийнхүү хэрэглээний импорт тэлэх шалтгаан боллоо.

Мөн өмнөх улиралд буураад байсан хөрөнгө оруулалтын бүтээгдэхүүний импорт эргэн сэргэж, тайлант улиралд 13.2 хувиар өссөн байна. Тяньжин боомтод гацаад байсан манай улсын чингэлгүүдийг II улирлын дундаас эрчимтэй татан авсан нь импорт нэмэгдэх нэг шалтгаан байв.

Хүснэгт IV.3.2

Импорт 2-р улиралд 29.9 хувиар өсөв.

сая ам.доллар	2021 II	2022 II	Жилийн өсөлт %	Өсөлтөд эзлэх %
Нийт импорт	1737.4	2257.4	29.9	29.9
Хэрэглээний бүтээгдэхүүн	556.4	699.0	25.6	8.2
Түргэн эдэлгээт	367.3	378.6	3.1	0.7
Удаан эдэлгээт	189.2	320.4	69.4	7.6
Судлын автомашин	103.3	180.3	74.6	4.4
Хөрөнгө оруулалтын бүт.н	775.4	877.9	13.2	5.9
Нефтийн бүтээгдэхүүн	229.6	435.5	89.7	11.9
Дизель	127.4	243.4	91.1	6.7
Бусад шатахуун	102.2	192.1	87.9	5.2
Аж үйлдвэрлэлийн орц	173.2	238.4	37.6	3.8
Бусад	2.8	6.6	139.4	0.2


²¹ Гадаад худалдааны сарын тойм, Монголбанк

Эх сурвалж: ГЕГ, Монголбанк

Үйлчилгээний дансны алдагдал энэ оны II улиралд өмнөх оны мөн үеэс 92 сая ам.доллаароор тэлж, 384 сая ам.долларт хүрэв (Зураг IV.3.2). Энэ нь голлон ачаа тээврийн холбогдолтой зардал өмнөх оны мөн үеэс 120 орчим сая ам.доллараар өссөнөөр тайлбарлагдаж байна. Харин аялал, боловсрол, бизнесийн үйлчилгээтэй холбогдох зардал харьцангуй өмнөх оны мөн үеийн түвшинд хадгалагджээ.

Зураг IV.3.2

Үйлчилгээний дансны алдагдал 7.2 хувиар тэлэв.




Эх сурвалж: Монголбанк

Орлогын дансны алдагдал II улиралд 440 сая ам.доллар болж өмнөх оны мөн үеэс 31 сая ам.доллаароор сайжрав (Зураг IV.3.3). Үүнд Оюу толгойн хүүний төлбөрт төлсөн зардал өмнөх оны мөн үеэс бага байсан нь голлон нөлөөлжээ. Түүнчлэн, Засгийн газраас шинээр гаргасан бондуудын хүү харьцангуй бага байгаа нь хүүний зардал буурах нөхцлийг бүрдүүлжээ.

Зураг IV.3.3

Орлогын дансны алдагдал тэлэв.




Эх сурвалж: Монголбанк

Санхүүгийн дансны тэнцэл 2022 оны II улиралд 500 сая ам.долларын ашигтай байсан нь өмнөх оны мөн үеэс 179 сая ам.доллаарой сайжирсан үзүүлэлт боллоо. Үүнд, гадаадын шууд хөрөнгө оруулалт 29 сая ам.доллороор буурсан хэдий ч багцын хөрөнгө оруулалт 159 сая, бусад хөрөнгө оруулалт 27 сая ам.доллаарой тус тус өссөн нь эерэг нөлөөтэй байв. Багцын хөрөнгө оруулалт ийнхүү сайжирсан үзүүлэлттэй гарахад өмнөх оны II улиралд Мазаалай бондын эргэн төлөлт хийгдэж байсан суурь үе голлон нөлөөллөө.

Зураг IV.3.4

Санхүүгийн дансны ашиг өмнөх оны мөн үеэс нэмэгдэв.



Эх сурвалж: Монголбанк

ҮСХ-ны тооцоогоор Гадаад худалдааны нөхцөл 2022 оны 6-р сард өмнөх оны мөн үетэй харьцуулахад 11.7 хувиар сайжирсан байна. Тодруулбал, нефтийн бүтээгдэхүүний импортын үнэ өссөнөөс голлон шалтгаалж нийт импортын үнийн индекс 19.2 хувиар нэмэгдсэн хэдий ч нөгөө талаас нүүрсний хилийн үнэ 1.6 дахин өссөнөөс экспортын үнэ илүү хурдтай буюу 33.0 хувиар нэмэгдсэн нь худалдааны нөхцөл ийнхүү сайжрах шалтгаан болов.

Хүснэгт IV.3.3

Төлбөрийн тэнцлийн төсөөллийн таамаглал 2022 он

Төлбөрийн тэнцлийн төсөөлөлд оруулсан өөрчлөлт (2022)

Экспорт	Өмнөх төсөөллөөс буурсан
Биет хэмжээний төсөөлөл: Зэс↑, газрын тос↓	
Үнийн төсөөлөл: Зэс ↓, нүүрс↓, төмрийн хүдэр↓, алт↓, газрын тос↑	
Импорт	Өмнөх төсөөллийн орчимд
Өрхийн хэрэглээ өмнөх төсөөллөөс удааших → Хэрэглээний импортын төлбөр ↓	
Хөрөнгө оруулалтын бүтээгдэхүүний импорт↑	
Үйлчилгээ	Өмнөх төсөөллөөс муудсан
Экспортын нэгж зардал ↑ → Ачаа тээврийн зардал ↑	
Гадаад инфляц ↑ → Аялал жуулчлалын зардал ↑	
ГНХО	Өмнөх төсөөллөөс буурсан
Компаниудын ашигт ажиллагаа буурч, орлогын дахин хөрөнгө оруулалтын төсөөлөл буурав.	
Багцын ХО	Өмнөх төсөөллөөс сайжирсан
МУХБ-ны Самурай бондыг 2022 онд эргэн төлнө гэж таамаглаж байсан бол одоогийн төсөөлөлд 2023 онд эргэн төлнө гэж үзэв.	
Бусад ХО	Өмнөх төсөөллөөс буурсан
Бусад ХО хэлбэрээр оруулж ирэх Оюу-Толгойн гүний уурхайн бүтээн байгуулалтад шаардлагатай санхүүжилтийн хэмжээ ↓	

Эх сурвалж: Монголбанк



МОНГОЛБАНК